

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН



Аймаг, сумдын удирдлагууд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн холбогдох хууль, журмуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сүхбаатар сум

2018 он

АГУУЛГА	
Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар
Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Үндсэн мэдээлэл
Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	Бүлэг 1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар иргэдээс санал аваагүй 969.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэсэн байна.
Аудитын менежер Б.Батмөнх	1.1. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөж, холбогдох итгэлцүүрийн дагуу хуваарилсан байна.
Ахлах аудитор С.Баасансүрэн	1.1.1. Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.
Аудитор Ж.Цогт	1.1.2. 3 сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт төвлөрөх 8.8 сая төгрөгийн авлагыг төвлөрүүлээгүй байна.
	1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох итгэлцүүрийн дагуу хуваарилсан байна.
	1.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтад иргэдээс санал аваагүй болон зориулалтын бус төсөл, арга хэмжээг төлөвлөн, баталж, хэрэгжүүлсэн байна.
	1.2.1. Тайлант онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтад иргэдээс санал аваагүй 969.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
	1.2.2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
	1.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт гүйцэтгэх байгууллагууд хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
	1.3.1. ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.
	1.3.2. Аймаг болон сумд ОНХС-ийн хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.
	1.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын зарим заалтыг тодорхой болгох шаардлагатай байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл гарвал 70362442, 70363047, 70363040 дугаарын утас, Selenge@audit.gov.mn цахим сайтаар харилцана уу.	Бүлэг 2. СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс сангийн эх үүсвэрийн 73.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн хэлбэрт шилжсэн байна.
ХАЯГ: Сэлэнгэ аймгийн, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд	2.1.СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс сангийн эх үүсвэрийн 73.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн хэлбэрт шилжсэн байна.
2018 оны 11 дүгээр сар	2.1.1. Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги тооцож, орлого төвлөрүүлээгүй байна.
	2.1.2. Зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөвлөсөн орлогын 39.3 хувийг төвлөрүүлсэн бөгөөд 123.9 сая төгрөгийн алдангийн орлого олох боломжийг алдсан байна.
	2.2. СХС-ийн хөрөнгийг ижил чиглэлийн олон үйл ажиллагаанд хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөхөд үр нөлөө үзүүлэхгүй байна.
	2.2.1. Сумдын сонгон шалгаруулах зөвлөл нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлийг хугацаанд нь төлөх төлбөрийн чадварыг бодитоор үнэлээгүй байна.
	2.2.2. Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хугацаандаа төлөгдөхгүй байх зэргээр гэрээний зарим зүйл, заалт хэрэгжээгүй байна.
	2.2.3. СХС-аас олгосон зээлийн 22.7 хувийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

2.3. Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо сул, зарим сумдын санхүүгийн тайлан үнэн зөв тайлагнагдаагүй байна.

2.3.1. Журамд СХС-ийн удирдлага, зохион байгуулалтыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй аймгийн ХХААГ болон тус санг хариуцсан мэргэжилтнүүдийн эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалт тусгагдаагүй байна. СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт шалгалт үр нөлөө муутай байна.

2.3.2. СХС-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

2.3.3. Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцоогүй байна.

2.4 “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Бүлэг 3. Сангуудын зарцуулалтад өмнөх онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж нь ОНХС- 71.1 хувь, СХС- 81.2 хувийн хэрэгжилттэй байна.

3.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмж дунджаар 71.1 хувийн биелэлттэй байна.

3.1.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

3.1.2. Өмнөх оны аудитаар өгөгдсөн актыг 100 хувь, албан шаардлагыг 53.3 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.2. Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 85.5 хувь байна.

3.2.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 56.5 хувьтай байна.

3.2.2. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт судалгаа

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МУ	Монгол улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТБОНӨБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үзүүлэлт
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
ХАА	Хөдөө аж ахуй

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 3 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

ОНХС болон СХС-ийн хөрөнгийн 2017 оны зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх,
- СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх,
- Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХС-ийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, СХС-ийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагналыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон СТСХ, ХХААГ, Орон нутгийн өмчийн газар, Санхүү хяналт, аудитын алба, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ, сумдын Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч, ХАА-н тасгийн мэргэжилтэн зэрэг албан тушаалтнуудыг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, лавлагаа тайлбар авах, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, тооцоолол хийх, иргэдээс санал асуулга авч дүнг нэгтгэн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын тайлан, дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ТБОНӨХБАҮХА тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- 2014 оны 43 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”,
- 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”,
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж болон холбогдох бусад хууль эрхийн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, Б.Эрдэнэзул, А.Дашбат нар 2018 оны 9 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

2017 онд аймаг, сумдын ОНХС-д мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 543.3 сая төгрөгийн, ОНХНС-аас орлогын шилжүүлгийн 2,139.7 сая төгрөгийн зэрэг нийт 2,683.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөж, төлөвлөсөн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4-р сарын 14-ний өдрийн хуулиар ОНХНС-аас Сэлэнгэ аймагт хуваарилсан 2,139.7 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2017 оны 5-р сарын 5-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор аймагт 1,345.1 сая төгрөгийг, сумдад 794.6 сая төгрөгийг хуваарилж, баталсан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 1,514.1 сая төгрөгийн 83 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 1,436.6 сая төгрөгийн өртөгтэй 75 ажил нь бүрэн, 77.5 сая төгрөгийн өртөгтэй 8 ажил нь дутуу хэрэгжиж, 101.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил огт хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.2-т “Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна” гэж заасан байна.

Сумдууд 2017 онд зээлийн эргэн төлөлтөөс 656.6 сая төгрөгийн, зээлийн хүүгийн орлогоос 43.6 сая төгрөгийн зэрэг нийт 700.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 86 төсөл сонгон шалгаруулан, 491.6 сая төгрөгийн зээл олгосон байна.

Тайлант онд иргэдийн ирүүлсэн төслийн үр дүнд 202 ажлын байр бий болгохоос 155 ажлын байр бий болж, 76.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Бүлэг 1

ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар иргэдээс санал аваагүй 969.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

1.1. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөж, холбогдох итгэлцүүрийн дагуу хуваарилсан байна.

1.1.1 ОНХНС-аас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хууль журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөсөн үү?

Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшууллаас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

УИХ-ын 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн “2017 оны Төсвийн тухай хууль”-иар ОНХНС-аас Сэлэнгэ аймгийн ОНХС-д 3,175.6 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор баталсан байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4-р сарын 14-ний өдрийн хуулиар ОНХНС-аас Сэлэнгэ аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1610,7 сая төгрөг, Тогтвортой 3 төслөөс сумдад олгох урамшуулал 529,0 сая төгрөг зэрэг 2,139.7 сая төгрөг болгон 32.6 хувиар бууруулж хуваарилсан байна.

Тайлант онд аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийг зөвхөн ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг болон тогтвортой амьжиргаа төслийн урамшууллын дүнгээр төлөвлөсөн бөгөөд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх, зарлагыг хэмнэх, дотоод гадаадын хандив, тусламж, аймгийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг зэрэг эх үүсвэрүүдийг тооцоолж, төлөвлөөгүй байна.

1.1.2 ОНХНС-аас олгох шилжүүлэг болон бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бүрдүүлсэн үү?

3 сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт төвлөрөх 8.8 сая төгрөгийн авлагыг төвлөрүүлээгүй байна.

Тайлант онд аймаг, сумдын ОНХС-д мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдлээс 543.3 сая төгрөг, ОНХС-аас орлогын шилжүүлгийн 1,610.7 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа 3 төслөөс 529,0 сая төгрөг зэрэг нийт 2,683.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөсөн нь бүрэн биелсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 /сая төгрөг/

Үзүүлэлтүүд	Аймгийн ОНХС эх үүсвэр		Сумын ОНХС эх үүсвэр		Нийт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	134.4	134.4	408.9	408.9	543.3	543.3	
Авлагын эхний үлдэгдэл	-	-		0.1		0.1	
Эх үүсвэр	ОНХС-аас шилжүүлэг	1,345.1	1,345.1	265.6	265.6	1,610.7	1,610.7
	Тогтвортой амьжиргаа төслөөс олгох			529.0	529.0	529.0	529.0
Нийт эх үүсвэрийн дүн	1,479.5	1,479.5	1,203.5	1,203.6	2,683.0	2,683.1	

Сумдын ОНХС-д 2013 оноос үүссэн 4 сумын нийт 8.9 сая төгрөгийн авлагыг төвлөрүүлж, зарцуулах боломжтой байсан боловч Сант сум /2013 онд гэрэлтүүлгийн ажил хийж гүйцэтгэсэн Автомастер ХХК-д илүү шилжүүлсэн / 0.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж, төвлөрүүлсэн бол дараах 3 сум 8.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Үүнд:

- Ерөө сум нь 2014 онд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын техник хяналтын зардалд 1.4 сая төгрөгийг илүү шилжүүлсэн авлагыг,
- Сайхан сум нь 2014 онд “Дулаан орц” хөтөлбөрийг гүйцэтгэсэн “Өлзийт хөтөл” ХХК-д 1.4 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосныг нөхөн төлүүлэхээр 2015 онд шүүхэд шилжүүлсэн боловч өнөөг хүртэл барагдаагүй,
- Түшиг сум нь 2013 онд цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан Баатарбулаг ХХК-д 6.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч уг ажлыг хийж гүйцэтгээгүй тул 2015 онд шүүхэд шилжүүлсэн боловч өнөөг хүртэл шийдэгдээгүй байна.

1.1.3. ОНХС-д олгох шилжүүлгийг холбогдох журмын дагуу хуваарилсан уу?

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох итгэлцүүрийн дагуу хуваарилсан байна.

УИХ-ын 2016 оны 11-р сарын 10-ны өдөр баталсан “2017 оны Төсвийн тухай хууль”-иар ОНХС-аас Сэлэнгэ аймагт хуваарилсан 3,175.6 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 2-ны өдрийн 16 дугаар тогтоолоор аймагт 2,030.9 сая төгрөгийг, сумдад 1,144.7 сая төгрөг байхаар хуваарилж, баталсан байна.

2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4-р сарын 14-ний өдрийн хуулиар ОНХНС-ийн орлогын шилжүүлэг болон Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгосон урамшуулал зэрэг нийт 2,139.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 5-р сарын 5-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор ОНХНС-аас тус аймагт хуваарилагдсан орлогын шилжүүлэг болон болон Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгосон урамшуулал 2,139.7 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл 134.4 сая төгрөг зэрэг нийт 2,274.1 сая төгрөгийн эх үүсвэрээс аймгийн ОНХС-д 754.3 сая төгрөг, сумдын ОНХС-д 794.6 сая төгрөг, мал эмнэлгийн болон хот тохижилтын үйлчилгээний зардалд 725.2 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн заавар” зэрэг эрх зүйн актуудыг үндэслэн хуваарилахаар зохицуулагдсан байдаг.

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 9.2¹-т заасны дагуу ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ гэсэн 4 итгэлцүүрт үндэслэн төлөвлөж байсан.

Төсвийн тухай хуулийн 59.2²-т 2016 оны 9-р сарын 9-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр ОНХНС-аас олгох шилжүүлгийн орлогын 30-аас доошгүй хувийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ гэсэн 3 итгэлцүүрээр тооцохоор болсон бөгөөд 2017 онд Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 40х30х30 гэсэн хувиар тооцож, хуваарилсан байна.

ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг болон Тогтвортой амьжиргаа 3 төслөөс олгох урамшууллын хуваарилалтыг сумдаар хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт 2 /сая төгрөг/

Д/д	Сумд	Хүн амын тоо-40%	Алслалт-30%	Нутаг дэвсгэр-30%	ОНХНС-аас олгох дүн	Тогтвортой амьжиргаа төслийн урамшуулал	Нийт дүн
1	Алтанбулаг	4.8	0.9	4.0	9.8	12.2	22.0
2	Баруунбүрэн	3.1	8.3	5.5	16.9	58.7	75.6
3	Баянгол	5.5	6.6	3.8	15.9	7.8	23.7
4	Ерөө	6.4	3.4	15.9	25.7	-	25.7
5	Жавхлант	2.0	2.4	2.3	6.7	21.9	28.6
6	Зүүнбүрэн	2.7	1.7	2.3	6.7	40.2	46.9
7	Мандал	26.9	8.7	9.4	45.0	-	45.0
8	Орхон	2.4	6.6	2.5	11.5	23.7	35.2
9	Орхонтуул	3.7	9.0	5.7	18.4	44.7	63.1
10	Сайхан	9.3	6.0	2.5	17.8	47.2	65.0
11	Сант	1.9	7.2	2.7	11.8	31.5	43.3
12	Сүхбаатар	22.5		0.1	22.6	37.7	60.3

¹ Аймаг, нийслэл нь ОНХНС-аас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахад энэ аргачлалын 3 дугаар зүйлд заасан мэдээллийг ашиглан мөн аргачлалын 4-8 дугаар зүйлд заасан итгэлцүүрүүдийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно.

² Аймаг, нийслэл нь ОНХНС-аас улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум, дүүргийн ОНХС-д хуваарилна: 59.2.2. энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах

13	Хушаат	1.8	3.4	3.9	9.1	40.2	49.3
14	Хүдэр	2.4	6.0	5.5	13.9	12.4	26.3
15	Түшиг	1.7	5.1	4.8	11.6	51.9	63.5
16	Цагааннуур	4.7	3.4	7.4	15.5	57.5	73.0
17	Шаамар	4.0	0.8	1.3	6.1	41.3	47.4
	Сумдын дүн	106.2	79.7	79.7	265.6	529.0	794.6

Харин Тогтвортой амьжиргаа 3 төслөөс Ерөө, Мандал сумдаас бусад 15 сумын ОНХС-д тус бүр 7.8- 58.7 сая, нийт 529,0 сая төгрөгийн урамшуулал хуваарилан санхүүжүүлсэн байна.

Тайлант онд ОНХС-аас 1,610.7 сая төгрөгийн, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 529.0 сая төгрөгийн зэрэг нийт 2,139.7 сая төгрөгийн орлогыг хуваарийн дагуу санхүүжүүлсэн байна.

ОНХС болон Тогтвортой амьжиргаа 3 төслөөс аймгийн ОНХС-д олгохоор хуваарилагдсан 2,139.7 сая төгрөгийн орлогын 84.3 хувь буюу 1,803.2 сая төгрөгийг 1-10 сард, 15.7 хувь буюу 336.5 сая төгрөгийг 11 сард шилжүүлсэн бол аймгийн ОНХС-аас 1-7 хоногийн дотор сумдын ОНХС-д шилжүүлсэн байна.

1.2. ОНХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал аваагүй болон зориулалтын бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

1.2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг баримталсан уу?

Тайлант онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс санал аваагүй 969.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын Засаг дарга нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3³, 12.1.5⁴, 12.2.5⁵, 12.2.7⁶-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний

³ ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална: 6.3.1. Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах, 6.3.4 орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх, 6.3.5 иргэдийн оролцоог хангасан байх.

⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-д заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт хүргүүлнэ.

⁵ Сум, дүүргийн ЗДТГ нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална:

⁶ Сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

жагсаалтыг боловсруулж, тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс өмнөх оноос шилжин ирсэн 2, 2017 онд шинээр эхлэх 6 зэрэг нийт 8 төсөл арга хэмжээнд 704.3 сая төгрөг, аймгийн баяр наадмын үйл ажиллагаанд 50.0 сая төгрөг, сумдын ОНХС-д 794.6 сая төгрөг, мал эмнэлэг, хот тохижилтын зардалд 725.2 сая төгрөг зэрэг нийт **2,274.1 сая** төгрөг зарцуулахаар баталсан байна. / Дэлгэрэнгүйг хавсралт №1-д харуулав /

2017 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.17⁷, 2.1.19⁸-т тусгагдсан 133.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бол бусад 452.6 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөртэй уялдаагүй байна.

Сүхбаатар сум “Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл”, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулалгүйгээр 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6-р багийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт болон ногоон байгууламж, Түшиг сум 8.8 сая төгрөгийн төсөв өртөгтэй халаалтын шугамын өргөтгөл, малын эрүүл мэндийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60.3⁹, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1¹⁰, 12.2.1¹¹-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, санал авч, эрэмбэлэх ажил хийгдээгүй байна.

Сумдын хувьд Баянгол, Баруунбүрэн, Жавхлант, Сант, Орхон, Орхонтуул, Мандал, Түшиг, Шаамар сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь багийн ИНХ-аас ирүүлсэн иргэдийн саналыг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан эрэмбэлж, ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг гаргасан байна.

Харин Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Сүхбаатар сумдууд ажлын хэсгийг байгуулаагүй бөгөөд багийн ИНХ-аас гарсан саналыг эрэмбэлээгүй, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг гаргаагүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй нийт 969.9 сая

⁷ Аймгийн нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасаг байгуулж, компьютер томографийн аппаратаар хангаж, хэрэглээний халуун устай болгоно.

⁸ Эрүүл мэндийн байгууллагуудын засвар үйлчилгээ, түргэн тусламжийг техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, эх аппаратаар хангах ажлыг үе шаттайгаар хийнэ.

⁹ 60.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6 Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээ;

¹⁰ Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна.

¹¹ Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд нээлттэй санал асуулгыг явуулна.

төгрөгийн 37 төсөл, арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60.3¹² дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /сая төгрөг/

Д/д	Аймаг, сум	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Аймаг	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн саравчийг гүйцээж стандарт зүлэгтэй хөл бөмбөгийн талбай байгуулах	327.0
2		Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх	53.0
3		Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах	48.5
4		Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах	45.6
5		Сайхан сумын таеквондогийн Мараната клубын барилгын гадна, дотно сантехникийн ажил	58.0
6		Орхон сумын сургуулийн дээвэр засвар	80.0
7		Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засварын ажил	31.5
8	Алтанбулаг	Цэцэрлэгжүүлэлт	3.0
9		Дунд сургуульд гадаад хэлний кабинет тохижилт	5.0
10	Хүдэр	Нохой устгал	0.1
11		Соёлын төвийн өргөтгөл	26.3
12	Хушаат	Ахуйн үйлчилгээний засвар	1.0
13		Рашаантын хөтлийн зам	3.0
14		Ногоон байгууламж	0.2
15		Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болох	4.5
16		Гудамжны тохижилт	4.0
17		Төв зам засварлах	10.0
18	Мандал	Асфальтан замын зураг, төсөв хийлгэх	57.7
19	Баруунбүрэн	Цэвэр усны шугам солих, гүний худгийн засварын ажил	20.3
20		Ивэнгийн 1-р багт сүү хүлээх авах танк байрлуулах засах, байшин барих	2.0
21	Түшиг	Цэцэрлэгийн засвар, тохижилтын ажил	2.5
22		ЕБС-ийн засвар, тохижилтын ажил	2.5
23		Нийтийн эзэмшлийн хөрөнгийг сэргээн засварлах ажил	5.0
24		Халаалтын шугамын өргөтгөлийн ажил	3.8
25		Малын эрүүл мэндийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	5.0
26		Бусад нийтийн эзэмшлийг дэмжих ажил	4.0
27		Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил	1.0
28		Нам давааны хөшөөг сэргээн засварлах ажил”.	5.0
29	Сант	Наадмын талбайн задгай суудлын саравч барих ажил	9.2
30	Сайхан	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын засвар үйлчилгээний зардал	3.4
31		ОНХС-ийн мэдээлэл сурталчилгааны ажил	1.0
32	Сүхбаатар	Нохойн устгал	20.0
33		Орхон 6-р баг цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	80.0
34		Орхон 6-р баг цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж	30.0
35	Зүүнбүрэн	Нохой устгал	1.0
36		Бохирын машины сэлбэг худалдан авах ажил	2.8
37		Баяр наадмын талбайн засвар, арчлалт	6.0
38		Сумын хог хаягдал цэвэрлэх, арчлалтын зардал	7.0
Нийт дүн			969.9

¹² Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6. орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

Багийн ИНХ нь хууль журамд заасан хугацаанд хуралдаагүй, ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцож, иргэдийн саналыг авч эрэмбэлсэн, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтлөөгүй, хурлын ирцийг оролцогчдын гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.2¹³, 5.4¹⁴, 5.5¹⁵ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Алтанбулаг сумын 1, 2, 3, Баруунбүрэн сумын 1,2,3, Сайхан сумын 2, Хүдэр сумын 1, Шаамар сумын 2, 3, Мандал сумын 1- 8 дугаар багийн ИНХ-ын дарга нар нь иргэдийн санал авах хурлыг 6-12 сард хуралдуулсан,
- Алтанбулаг сумын 1, 2, Ерөө сумын 3, Сайхан сумын 1, 2, Сүхбаатар сумын 1-8, Хүдэр сумын 1-р багийн ИНХ-ын дарга нар нь хурлын ирцийг бүртгэж, оролцогчдоор гарын үсэг зуруулаагүй, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөөгүй .
- Шаамар сумын 1, 3-р багийн ИНХ-ын дарга нар нь хурлын ирцийг бүртгэж, оролцогчдоор гарын үсэг зуруулаагүй,
- Баруунбүрэн сумын 1, Орхон сумын 2-р багийн ИНХ-ын дарга нь хуралд оролцогчдын ирцийг гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй,
- Сант сумын 2, Сайхан сумын 3, Мандал сумын 2, 3, 4, 5, Хушаат сумын 2, Шаамар сумын 3-р багийн багийн ИНХ-ын ирц хүрээгүй, хүчин төгөлдөр бус хурлаар иргэдийн саналыг эрэмбэлж, жагсаалтыг баталсан,
- Алтанбулаг сумын 3, Хүдэр сумын 2-р багийн ИНХ хуралдаж, иргэдийн санал авах үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Жавхлант сумаас бусад сумдын багийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг багийн ИНХ-аар хэлэлцүүлэх хурлын зарыг айл өрх бүрд хүргэж, зар хүлээн авсан гарын үсгээр баталгаажуулаагүй байгаа нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.3¹⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

ТЭЗҮ, зураг төсөв, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад тусган, батлуулахаар зохицуулагдсан байдаг атал аймгийн ОНХС-аас 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 төсөл, арга хэмжээнээс 53.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх зардал, 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах зэрэг 2 төсөл, арга хэмжээний зах зээлийн үнийн судалгаа, төсвийг хийлгүйгээр төсөвт өртгийг багцаалан тусгаж, батлуулсан байна.

80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Орхон сумын сургуулийн дээвэр засвар” , 31.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засвар”-ийн ажлуудыг аймгийн ИТХ-аар батлуулсны дараа буюу 2017 онд төсөвт өртөгт нь багтаан Талхун Арал ХХК-иар зураг, төсвийг нь гүйцэтгүүлсэн байна.

¹³ Баг, хороодын иргэдийн Нийтийн Хурлын /цаашид Нийтийн хурал гэх/ дарга ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг жил бүрийн 5 дугаар сард багтаан зохион байгуулна.

¹⁴ Баг, хорооны Нийтийн хурлыг Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.10 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

¹⁵ Баг, хорооны ИНХ-ын дарга хурлын ирцийг бүртгэн оролцогчдоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж тэмдгээр баталгаажуулна.

¹⁶ Баг, хорооны Засаг дарга Нийтийн хурлын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрт хүргэж, зар хүлээн авсан гарын үсгийг айл өрх бүрээс авч баталгаажуулна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 100 төсөл, арга хэмжээнээс 8 сум 83 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгэсэн бол 148.1 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг хяналтын зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Алтанбулаг	Цэцэрлэгжүүлэлт	3.0
2		Жишиг гудамж	8.5
3	Ерөө	Тавин багийн төвийн байр засварлах	10.0
4		1-р багийн гүний худгуудын засвар	5.0
5	Баянгол	Хараа багт худаг шинээр гаргах	5.0
6		Ахуйн үйлчилгээний засвар	1.0
7		Рашаантын хөтлийн зам	3.0
8		Гудамжны гэрэлтүүлэг	4.1
9	Хушаат	Нийтийн халуун усны засвар	2.6
10		Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болох	4.5
11		Гудамжны тохижилт	4.0
12		Төв зам засварлах	10.0
13		Эрчим хүчний шугам татах	12.9
14	Мандал	6-р багийн нутаг дэвсгэрт гүний худаг 2-г барих	23.0
15	Орхонтуул	Хогны машин худалдан авах	20.0
16	Сүхбаатар	Нохой устгал	20.0
17	Түшиг	Зөгий хөтөлбөр	11.5
		Нийт дүн	148.1

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсвийг урьдчилж хийлгэхгүй байгаа шалтгааны талаар сумдын Санхүүгийн албаны дарга нараас асуулга авахад:

- “ОНХНС-ийн шилжүүлгийн орлогоос сумдад хуваарилах тоо хэмжээ нь урьдчилан мэдэгддэггүй учир хуваарилсны дараа тоо хэмжээнд нь тохируулж төсөл, арга хэмжээг сонгодог,
- Зураг, төсөв зохиогч нь ажлын хөлсийг урьдчилж авах шаардлага тавьдаг тул урьдчилж хийлгэх хөрөнгө санхүү байдаггүй,
- Зураг, төсвийг урьдчилж хийлгээд тухайн төсөл, арга хэмжээ ИТХ-аар батлагдахгүй тохиолдолд үргүй зардал гарах, эх үүсвэр нь шийдэгдэхгүй өр төлбөр үүсэх зэрэг эрсдэл үүсдэг” гэсэн тайлбар өгч байлаа.

Нөгөө талаас, хэдийгээр аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсвийг тухайн шатны ИТХ-аар батлахын өмнө болон батлагдсаны дараа төсөвт өртөгт нь багтаан хийж байгаа ч уг зураг, төсөв нь үнэн зөв эсэхийг магадлах ажил огт хийгдэхгүй байна.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчил давтагдсаар байна.

Төсвийн тухай хуулийн 58.2¹⁷, 58.4¹⁸, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн заавар”-ын 7.2¹⁹, 7.4²⁰-т аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 7-12 төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас малжуулах, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх гэсэн 3 чиг үүргээс бусад чиг үүргийн 100 төсөл, арга хэмжээнд 2,092.1 сая төгрөгийг дараах зориулалтаар зарцуулсан байна. Үүнд:

- *Орон нутгийн өмчийн барилга, байгууламж бий болгох, их засвар хийхэд 9.9 хувь буюу 207.4 сая төгрөг,*
- *Нийтийн тээврийн үйлчилгээгээр хангах, машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад 2.2 хувь буюу 45.7 сая төгрөг,*
- *Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулах ажилд 34.5 хувь буюу 721.9 сая төгрөг,*
- *Малын угаалгын банн, тарилгын хашаа барих ажилд 0.6 хувь буюу 11.7 сая төгрөг,*
- *Худаг шинээр гаргах, засах ажилд 3.2 хувь буюу 66.2 сая төгрөг,*
- *Сумын нутаг дэвсгэрт усны шуудуу татах, засах ажилд 1.7 хувь буюу 37.0 сая төгрөг,*
- *Сумын доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээний зардалд 3.0 хувь буюу 64.1 сая төгрөг,*
- *Сумын тохижилт, цэцэрлэгжүүлэлт, явган хүний зам, гарц гаргах, хүүхдийн тоглоомын талбай байгуулахад 17.2 хувь буюу 359.3 сая төгрөг,*
- *Сургууль, цэцэрлэг, соёлын төв, нийтийн биеийн тамирын барилгын засвар, анги, танхимын тохижилтод 7.9 хувь буюу 165.3 сая төгрөг,*
- *Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, тоног төхөөрөмж авахад 0.25 хувь буюу 5.5 сая төгрөг,*
- *Зураг төсөв хийлгэх зардалд 4.1 хувь буюу 86.0 сая төгрөг*
- *Баяр наадмын зардалд 3.3 хувь буюу 70.0 сая төгрөг,*
- *Удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд 12.0 хувь буюу 252.1 сая төгрөг,*

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 1,514.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 1,436.6 сая төгрөгийн өртөгтэй 75 төсөл, арга хэмжээ бүрэн, 77.5 сая төгрөгийн өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжиж, 101.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Судалгаа №3 -т харуулав /.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл, арга хэмжээнээс худалдан авах ажиллагаа нь оройтсон болон хэт жижиглэж төлөвлөсөн 101.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- *Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 48.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах”*
- *Алтанбулаг суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 0.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нохой устгал”,*

¹⁷ Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.2.1-58.2.17 хүртэл 17 чиг үүрэг хуульчлагдсан байна.

¹⁸ Сум өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ: 58.4.1-58.4.11 хүртэл 11 чиг үүрэг хуульчлагдсан байна.

¹⁹ Аймаг ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.2-т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно. 7.2.1-7.2.12 хүртэл чиг үүрэг

²⁰ Сум ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58.4-т заасан дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно.

- Сант суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв”,
- Сайхан суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын засвар үйлчилгээний зардал”
- Хушаат суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 0.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж”, “Хогийн цэг”
- Шаамар суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 34.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай”,
- Түшиг суманд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зураг төсөв”, 7.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аарц хөргүүрийн цех”

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжсэн 92 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 31 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 60 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Үүнээс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын, 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Сайхан сумын Засаг даргад шилжүүлсэн байна.

Гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бол харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах 5 төсөл, арга хэмжээний “Ажлын хэсэг”-ийг аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар тус газрын ажилтан болох 3 хүний бүрэлдэхүүнтэй, хэт явцуу хүрээнд байгуулсан нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

53.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүй шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1²¹, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан ТБОНӨХБАУХА ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн 2²² дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

31.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн их засварын ажил”-ын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 33.2²³ дахь заалтыг зөрчсөн байна.

Сумдад томилогдсон 23 ажлын хэсгийн 85 гишүүнээс худалдан авах ажиллагаанд мэргэшсэн, АЗ сертификат бүхий 10 гишүүн ажилласан байгаа нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 47.6²⁴ дахь заалтыг зөрчсөнөөс гадна худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

²¹ Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно: 8.1.1. шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

²² Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 10.0 сая төгрөг, ажил 10.0 сая

²³ Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ: 33.2.1. Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх.

²⁴ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

Сумдын ажлын хэсэг нь 227.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 /сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
1	Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус худалдан авах	45.6	Ди Ти И Эм строй ХХК
2	Хүдэр сумын Соёлын төвийн өргөтгөл барих	26.3	Хатант констракш ХХК
3	Сүхбаатар сумын Орхон 6-р баг цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	80.0	Амьд газар ХХК
4	Сүхбаатар сумын Орхон 6-р баг цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж	30.0	Амьд газар ХХК
5	Сүхбаатар сумын Нохой устгал	20.0	ИЗЗИ ХХК
6	Сант сумын Бургастай хорооллын жишиг гудамж бий болгох	15.0	Голомт констракшн ХХК
7	Түшиг сумын Зөгий хөтөлбөр	11.0	Эко бал ХХК
	Нийт дүн	227.9	

Сумдын ажлын хэсэг нь 322.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа нэг ч үнийн санал ирээгүй болон тендерийн материалын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй гэх үндэслэлээр тендерийг хүчингүй болгосон боловч шаардлага хангаагүй гэж хасагдсан болон огт үнийн санал ирүүлээгүй аж ахуйн нэгжид шууд гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлж, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 /сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Урилга илгээсэн аж ахуйн нэгж	Үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгж	Шууд гэрээ байгуулсан аж ахуйн нэгж
1	Баянгол сумын Спорт заалны дээврийн засвар	30.2	Алтан хүнс групп ХХК Тэнгэр шилүүстэй ХХК Суч ХХК	Алтан хүнс групп ХХК Тэнгэр шилүүстэй ХХК	Белит ХХК
2	Жавхлант сумын Үерийн усны шуудуу засах	37.0	Баянчандмань АЗЗА Налайх АЗЗА Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК	Баянчандмань АЗЗА Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК	Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК
3	Мандал сумын 6-р багийн нутаг дэвсгэрт гүний худаг гаргах	23.0	Ханна ундарга ХХК Орхон гидрогео ХХК Гидро-тех инженеринг ХХК	Нэг ч санал ирээгүй	Ус ундарга ХХК
4	Орхонтуул сумын Хогны машин худалдан авах	20.0	Визард экспресс консалтинг ХХК Санний гоулд хаус ХХК Лүн арвижих ХХК	Нэг ч санал ирээгүй	Визард экспресс консалтинг ХХК
5	Сайхан сумын Бичил хорооллуудын дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	45.0	Дархан уянга ХХК Талст өргөө ХХК Сайхан төгөл ХХК	Талст өргөө ХХК	Талст өргөө ХХК

6	Сайхан сумын Номгон 3-р багт цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих	16.0	Эвсэг бүлэг Залуус бүлэг Номгоны нөхөрлөл	Эвсэг бүлэг	Эвсэг бүлэг
7	Сайхан сумын Явган хүний зам	26.5	Тойрог сүлд ХХК Бумбат даваа ХХК Хөтөл хишиг ХХК	Хөтөл хишиг ХХК	Хөтөл хишиг ХХК
8	Орхонтуул сумын Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	76.7	Титан оргил ХХК Смарт лифт ХХК Монкароташ ХХК	Титан оргил ХХК	Титан оргил ХХК
9	Орхон сумын Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	19.9	Нартнилчин хоршоо Нилчиндалай хоршоо Цэвэр орчин бүлэг	Нартнилчин хоршоо	Нартнилчин хоршоо
10	Баруунбүрэн сумын Сумын төвд камер тавих	15.0	Орхон нүнжиг ХХК Тойрог сүлд ХХК Шинэ эрдэнэт констракшн ХХК	Орхон нүнжиг ХХК	Орхон нүнжиг ХХК
11	Зүүнбүрэн сумын Гудамж талбайн хаягжуулалт	13.0	Хайвэй интернэшнл ХХК, Зоригсайхан, Лхагвабаяр	Хайвэй энтернэшнл ХХК	Хайвэй энтернэшнл ХХК
	Нийт дүн	322.3			

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулан, төсөвт өртгөөр нь гүйцэтгүүлж байгаа нь үнийн харьцуулалт хийж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгжийг сонгох зарчим алдагдаж, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Хушаат сум 12.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрчим хүчний шугам татах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бол Мандал сум 57.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Асфальтан замын зураг, төсөв хийлгэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг үнэлэхдээ Сангийн сайдын 2008 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”-ыг баримталж, үнэлгээний хуудсаар үнэлээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааг НТШ-аар зохион байгуулсан 1, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 зэрэг нийт 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгэхээс 4 төсөл, арга хэмжээний / 1 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй, зөвхөн худалдан авах ажиллагаа нь хийгдсэн / явцын болон техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн бол 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан бассейны дулааны шугамын ажил”, 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах” 2 төсөл, арга хэмжээнд хяналт хийлгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 37.2²⁵, Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2²⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан 25 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхээс 9 төсөл, арга хэмжээний хяналтыг орон нутгаас, 12 төсөл, арга хэмжээний хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн бол 70.8

²⁵ Захиалагч барилгын ажлын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

²⁶ Энэ дүрмийн 2.1-д заасан барилга захиалагч нь мөн дүрмийн 3.1-д зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 3.2.5. орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга захиалагчийн албаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх

сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 4 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгээгүй байна. Үүнд:

- Орхон сумын 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах”,
- Сант сумын 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бургастай хорооллын жишиг гудамж бий болгох”,
- Мандал сумын 23.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “6-р багийн нутаг дэвсгэрт гүний худаг 2-г барих”,
- Хушаат сумын 12.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрчим хүчний шугам татах”

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга угсралт, их засварын ажлыг сумын комиссын актаар хүлээн авч байгаа боловч шууд худалдан авах аргаар хэрэгжсэн нийт 104.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хийгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7 /сая төгрөг/

Д/д	Сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Алтанбулаг	Гэрэлтүүлэг	9.0
2		Жишиг гудамж	8.5
3		Камержуулалт засвар	2.3
4	Ерөө	Тавин багийн төвийн байр засварлах	10.0
5		Гэрэлт хайлаастанд улаан булан барих	10.0
6		1-р багийн гүний худгуудын засвар	5.0
7	Баянгол	Хараа багт худаг шинээр гаргах	5.0
8	Баруунбүрэн	Сумын төвийн цэвэр усны 100 м шугам солих ажил	6.0
9	Хушаат	Ахуйн үйлчилгээ, нийтийн халуун усны засвар	3.6
10		Рашаантын хөтлийн зам	3.0
11		Гудамжны гэрэлтүүлэг	4.1
12		Гудамжны тохижилт	4.0
13		Төв зам засварлах	10.0
14	Сант	Наадмын талбайн задгай суудлын саравч барих ажил	9.2
15	Зүүнбүрэн	Хүүхдийн тоглоомын талбай засварын ажил	8.0
16		Сумын хог хаягдал цэвэрлэх, арчлалтын зардал	7.0
		Нийт дүн	104.7

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх барилга угсралт, их засварын 496.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний зураг төсөв болон зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр Талхун Арал ХХК-тай гэрээ байгуулснаас 59.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний явц болон гүйцэтгэлд хяналт хийсэн бол 437.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээнд хяналт хийгдэлгүйгээр зөвхөн ажил хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ажилласан байна.

Сумдын хувьд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт 436.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнд зураг, төсөв зохиогчийн хяналт хийгдээгүй, мөн л зөвхөн ажил хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ажилласан байгаа нь Барилгын тухай хуулийн 38.1.4²⁷, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд

²⁷ Зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх.

зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3²⁸, 5.2²⁹ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Зураг, төсөв зохиогчийн хяналтын зардалд аймгийн ОНХС-аас 3.5 сая төгрөгийн, сумын ОНХС-аас 5.0 сая төгрөгийн зэрэг нийт 8.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч зохиогчийн хяналт хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээг дүгнээгүй, хяналтын тэмдэглэл, дүгнэлт зэргийг бүрдүүлээгүй, өөрөөр хэлбэл анхан шатны баримтаар баталгаажаагүй буюу хяналт хийгдээгүй байхад санхүүжилтийн гүйлгээ хийсэн нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавигдах хяналт хангалтгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг актаар хүлээж аваагүй байхад дараахь төсөл, арга хэмжээнд нийт 150.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байгаа нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.5.10³⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8 /сая төгрөг/

Д/д	Аймаг, сумд	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Аймаг	Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх	53.0
2	Алтанбулаг	Камержуулалт засвар	2.3
3	Ерөө	1-р багийн гүний худгуудын засвар	5.0
4	Хушаат	Ахуйн үйлчилгээ, нийтийн халуун усны засвар	3.6
5		Рашаантын хөтлийн зам	3.0
6		Гудамжны гэрэлтүүлэг	4.1
7		Сумын байгуулалтын хэтийн төлөвлөгөөний зураглал хийлгэх	20.0
8		Гудамжны тохижилт	4.0
9		Төв зам засварлах	3.9
10	Мандал	Гэр хорооллын гудамжны зам талбай байгуулах ажил	7.9
11	Зүүнбүрэн	Бохирын машины сэлбэг худалдан авах ажил	2.8
12		Хүүхдийн тоглоомын талбай засварын ажил	8.0
13		Сумын хог хаягдал цэвэрлэх, арчлалт	7.0
14	Сант	Наадмын талбайн задгай суудлын саравч барих	9.2
15	Сайхан	24-р цэцэрлэгийн ард үерийн усны суваг дээр явган хүний гарц хийх	10.0
16		ОНХС-ийн мэдээлэл, сурталчилгааны зардал	1.0
17	Түшиг	Бусад нийтийн эзэмшлийн хөрөнгийг сэргээн засварлах ажил	5.0
18		Соёлын төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх	1.0
		Нийт дүн	150.8

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд бүрэн ашиглалтад оруулсан бол сумдын хувьд Зүүнбүрэн сумын 13.0 сая

²⁸ Барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

²⁹ Зохиогчийн хяналт гүйцэтгэсэн тэмдэглэл, бусад ашигласан маягтуудын хуулбар хувийг зохиогчийн хяналтын тэмдэглэлд хавсаргана. Зохиогчийн хяналтын тэмдэглэл дараах хэсгүүдээс бүрдэнэ: 5.2.1. Барилга байгууламжийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 1-ийн дагуу, 5.2.2. Захиалагчийн мэдээллийг Хавсралт№1-ийн Хүснэгт 2-ын дагуу, 5.2.3. Барилгын ажил гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт№1-ийн Хүснэгт 3-ын дагуу, 5.2.4.Туслан гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 4-ын дагуу, 5.2.5. Зохиогчийн хяналт гүйцэтгэгчийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 5,6-ын дагуу, 5.2.7. Зохиогчийн хяналт гүйцэтгэсэн тухай бүртгэлийн мэдээллийг Хавсралт №1-ийн Хүснэгт 7-ын дагуу, 5.2.8.Зохиогчийн хяналтын явцад захиалагч, барилгын ажил гүйцэтгэгчээс тодруулсан асуудлыг шийдвэрлэсэн бичиг баримтын бүртгэлийг Хавсралт №1-ийн Хүснэгт 8-ын дагуу, 5.2.9. Зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай бүртгэлийг Хавсралт №1-ийн Хүснэгт 9-ын дагуу тус тус тэмдэглэнэ.

³⁰ Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт

төгрөгийн төсөвт өртөгтэй “Гудамж талбайн хаягжуулалт”-ын ажил онд дамжин хэрэгжихээр болсон байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр Сайхан сумын хувийн хэвшлийн “Таеквондогийн Мараната клуб”-ын барилгын гадна, дотно сантехникийн ажилд 58,0 сая төгрөг төлөвлөж хэрэгжүүлсэн нь ОНХС-гийн зааврын 4.5 дахь “Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сүхбаатар сум худалдаа, нийтийн хоолны чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг ИЗЗИ компанитай байгуулсан гэрээний дагуу 1900 нохой устгуулсан гэж 2 удаагийн гүйлгээгээр 20,0 сая төгрөг шилжүүлсэн боловч устгаж, булсан нохойны тоо хэмжээг нотолж, дэмжсэн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байгаа нь гэрээт ажил үнэхээр хийгдсэн эсэх эргэлзээг төрүүлж байна. Өөрөөр хэлбэл 1900 нохой устгаж, булсан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхой бус байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4³¹, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн заавар”-ын 8.6³²-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхээр зохицуулагдсан байдаг.

Сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, холбогдох байгууллагуудад ашиглалт, хамгаалалтыг хариуцуулсан байна.

Харин аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 118,5 сая төгрөгийн өртөг бүхий дараах хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- *Захиалагч аймгийн ЗДТГ болон Орон нутгийн өмчийн газрын харилцан уялдаагүй ажиллагааны улмаас 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан бассейны дулааны шугам”,*
- *Хувийн эзэмшлийн барилгад зориулалтын бусаар зарцуулсан 59.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан сумын олимп таеквондогийн Мараната клубын барилгын гадна, дотор сантехникийн засвар” зэрэг болно*

Аудитын явцад 14 суманд хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг объект дээр нь очиж танилцахад ашиглагч байгууллагын зүгээс ямар нэгэн гомдол, санал гараагүй болно.



/Хүдэр сум. Соёлын төвийн өргөтгөл/




/Орхонтуул сум. Тоглоомын талбай/

³¹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага

³² ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.



/Сайхан сум. Хөлбөмбөгийн талбай/



/Сайхан сум. Сагсан бөмбөгийн талбай/

1.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг “ОНХС-ийн заавар”-ын дагуу тайлагнасан уу?

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт гүйцэтгэх байгууллагууд хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.3.1. ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд хууль журмын дагуу хяналт тавьж ажилласан уу?

ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн заавар”-ын 9.1³³, 9.4³⁴-т заасны дагуу тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавихаар зохицуулагдсан байдаг.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийгээгүй байна.

Сумдын хувьд Баянгол, Баруунбүрэн, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сайхан, Мандал, Хүдэр, Түшиг, Цагааннуур зэрэг 10 сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороод нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэл, хийгдсэн хөрөнгө оруулалтын чанар байдалд 1-2 удаа хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

Харин Зүүнбүрэн, Сант, Сүхбаатар сумдын ИТХ нь Хяналтын хороог байгуулаагүй, Алтанбулаг, Ерөө, Хушаат, Шаамар сумдын ИТХ нь 3-5 хүний

³³ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

³⁴ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

бүрэлдэхүүнтэй Хяналтын хороог байгуулсан боловч хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймаг, сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн заавар”-ын 9.2³⁵, 9.6³⁶-т дотоод аудитын албанаас аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавихаар зохицуулсны дагуу аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Зүүнбүрэн, Түшиг, Шаамар сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн гэх боловч ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

Дээрх байдлаас үндэслэн аймаг, сумдын ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд эрх бүхий байгууллагуудаас үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна гэж дүгнэж байна.

1.3.2. ОНХС-ийн хэрэгжилтийн явцыг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тайлагнасан уу?

Аймаг болон сумд ОНХС-ийн хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

2017 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумдууд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т, аймгийн Засаг дарга Сангийн яамны ОНХС-ийн хэлтэст хүргүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 10.1³⁷, 10.3³⁸ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 4-р сарын 18-ны А/173 дугаар захирамжаар аймаг, сумын ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх үүрэг бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг томилсон боловч уг ажлын хэсэгт үүрэг болгосон ажил нь хийгдээгүй байна.

Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээллийг Шилэн дансны тухай хууль, “ОНХС-ийн заавар”-ын 11.2.3³⁹-т заасны дагуу нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй байдаг.

Аймаг, сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, Сангийн яам, Худалдан авах ажиллагааны болон “Сэлэнгэ аймгийн цахим хуудас”-аар тухай бүр мэдээлж байна.

Сумдын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг “Төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбар”-т дараах байдлаар мэдээлсэн байна.

³⁵ ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтын дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.

³⁶ ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд орон нутгийн дотоод аудитын болон иргэдийн хөндлөнгийн хяналт тавина. Орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтыг дотоод аудитын тайлангийн хамт Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэр, залруулга, арга хэмжээг авна.

³⁷ Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7-р сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2-р сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ.

³⁸ Аймаг, нийслэл ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гаргасан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны ОНХС-ийн хэлтэст ирүүлнэ.

³⁹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна.



Сэлэнгэ аймгийн selenge.gov.mn , Сангийн яамны mof.gov.mn ,шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсуудаар тус сангийн худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн мэдээллийг нийтэд хүргэсэн байна.

Сэлэнгэ аймгийн selenge.gov.mn цахим хуудсаар мэдээлсэн байдал

№	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Санхүүжилтийн хэмжээ	Үндэслэлгүйн нэр, хэлбэр	Огноо
1	Мандал сумын Түнхэл тосгонд хайрган хүчилтэй зам тавих	94,130,000₮	86,913,400₮	68,671,771₮	Талхун арал ХХК, Сэлэнгэ Есөн эрдэнэ ХХК	2018-10-03
2	Баруунбүрэн суманд гүний худал гаргах	20,000,000₮	19,934,727₮	18,861,529₮	Талхун арал ХХК	2018-09-28
3	Сүхбаатар сумын ирвэс үсэг цэвэрлүүлэх тоног төхөөрөмж тавих	69,600,000₮	57,900,150₮	57,900,150₮	Сан ХХК	2018-09-28
4	Баруунбүрэн сумын соёлын төвийн дээвэр засвар	30,000,000₮	29,998,500₮	29,732,342₮	Талхун арал ХХК	2018-09-27
5	Орхонтуул сумын эмнэлгийн морьт, гражийн засвар	25,000,000₮	25,000,000₮	12,269,570₮	Орхонтуул ЭДТГ нэмэлт санхүүжилтийн данс	2018-09-27
6	Түшиг сумын сургуулийн бохирын шугам засварлах, бохир цэвэрлэх	34,594,000₮	34,594,000₮	33,998,501₮	Сэлэнгэ БЗА	2018-09-21
7	Ерөө суманд шинэ сургуулийн бүсийн цахилгаан хангамж, дэд станц	49,863,500₮	45,684,600₮	45,270,592₮	Сансвера ХХК	2018-09-05
8	Алтанбулаг суманд хүнсний ногооны чөлөөллийн бага оврын төлөв, усалгааны систем, хуланж авах	35,000,000₮	34,386,000₮	34,386,000₮	Кю Ги Арт констракшн ХХК	2018-07-31

Аймаг, сумын ЭДТГ-ууд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, гүйцэтгэгч байгууллагуудын талаарх мэдээллийг тухай бүрд нь мэдээлж байгаа боловч төсөл, арга хэмжээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн компаниуд мэдээллийг Шилэн дансны shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

1.4. ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журмын хоорондын нийцэл, бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх, сангийн үйл ажиллагаа нь зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн зарим асуудал байгаа эсэх.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын зарим заалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Төсвийн тухай хуульд 2016 оны 9-р сарын 9, 2017 оны 4-р сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан тул эдгээр өөрчлөлтүүдтэй уялдуулж Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал” , Сангийн сайдын 2012 оны 43 дугаар тушаалаар

батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т өөрчлөлт оруулах шаардлагатай юм.

Тайлант онд ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн 30-аас доошгүй хувийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ гэсэн 3 итгэлцүүрээр, Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 40х30х30 гэсэн хувиар тооцож, төлөвлөснийг Төсвийн тухай хуулийн өөрчлөлттэй уялдуулан журам, аргачлалд тусгах шаардлагатай байна.

Аудитын явцад “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын зарим заалтуудыг тодорхой болгох шаардлагатай дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтын журам”-тай уялдуулж, зааварт санхүүжилт олгоход баримтлах заалтуудыг тодорхой тусгах, санхүүжилтийг олгоход бүрдүүлэх баримтын жагсаалтад магадалшгүй ажлын төсөв, акт, зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлтийг бүрдүүлсэн байхаар нэмж оруулах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 5.1⁴⁰, 5.3⁴¹ дахь заалтын дагуу багийн Засаг дарга тухайн орон нутгийн айл өрх бүрээс санал авах, авсан саналыг эрэмбэлж ИНХ-ын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө айл өрх бүрт хүргэж, гарын үсгээр баталгаажуулахаар заасан байдаг. Сумдын Багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нар алслагдмал айл, өрхөд хүрч ажиллах хүн хүчний болон санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдаг, уг ажлыг хийхэд маш хүндрэлтэй байдаг тул ИНХ-ын хуралдах зар хүргэх хугацаанд өөрчлөлт оруулах.
3. Зааврын 12.1 дэх хариуцлага тооцох заалт нь тодорхой бус учир уг зааврыг мөрдөөгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд ямар хариуцлагыг хэрхэн ногдуулах талаар тодорхой болгох шаардлагатай байна.
4. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг цаг үеийн шинжтэй, төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэх, хэлбэрээр хэт жижиглэж, төлөвлөн, зарцуулж байгаа нь үр дүн муутай төсвийн үрэлгэн зарцуулалтыг нэмэгдүүлж байгаа тул аль болох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх чиглэл барьж журамд өөрчлөлт оруулах

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

ОНХС-ийн 2017 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар аймгийн хэмжээнд нийт **1,986.8 сая төгрөгийн** зөрчил илэрснээс **1,706.7 сая төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага, **280.1 сая төгрөгийн** зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Нэг. Албан шаардлага:

⁴⁰ Сум, дүүрэг, баг, хорооны түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” батлах тухай Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалыг баримтална.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 12.2.1 а/ баг, хорооны иргэдээс санал асуулгыг авахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна, 12.2.1 б/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1-р хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1-р улиралд багтаан хүргүүлнэ.

⁴¹ Баг, хорооны Засаг дарга Нийтийн хурлын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрт хүргэж, зар хүлээн авсан гарын үсгийг айл өрх бүрээс авч баталгаажуулна.

1. **Аймгийн ОНХС:** Иргэдээс санал авч, эрэмбэлээгүй нийт **643.6 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн. */Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-т харуулав/*
2. Хувийн хэвшлийн “ Таеквондогийн Мараната клуб”- ын барилгын гадна, дотно сантехникийн ажилд **58.0 сая төгрөгийг** төлөвлөж, хэрэгжүүлсэн, бүртгэл, тайланд тусгаагүй,
3. **53.0 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “*Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурилуулах, тээвэрлэх*” төсөл, арга хэмжээний төсвийг тооцоо судалгаагүйгээр, багцаалан төлөвлөж, хэрэгжүүлсэн бөгөөд гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээж авах комиссын акт гараагүй байхад **53.0 сая төгрөгийн** санхүүжилтийг бүрэн олгосон,
5. Зураг, төсөв зохиогчийн хяналтын гэрээг дүгнээгүй, хяналтын тэмдэглэл, дүгнэлт зэргийг бүрдүүлэлгүйгээр зохиогчийн хяналтын зардал **3.5 сая төгрөгийг** олгосон,
6. **Сумдын ОНХС:**10 сум иргэдээс санал авч, эрэмбэлээгүй нийт **326.3 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн, */Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-т харуулав/*
7. 8 сум нийт **148.1 сая төгрөгийн** өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээг хяналтын зураг, төсөвгүй, ямар ч тооцоо судалгаагүйгээр баталж, хэрэгжүүлсэн, */Дэлгэрэнгүйг Хүснэгт 4-т харуулав/*
8. **227.9 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа шаардлага хангасан 3 буюу түүнээс дээш эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдээгүй,
9. Зураг, төсөв зохиогчийн хяналтын гэрээг дүгнээгүй, хяналтын тэмдэглэл, дүгнэлт зэргийг бүрдүүлэлгүйгээр **5.0 сая төгрөгийн** зохиогчийн хяналтын зардлыг олгосон,
10. 8 сумын 17 төсөл, арга хэмжээг хүлээж авах комиссын акт гараагүй байхад нийт **97.8 сая төгрөгийн** санхүүжилтийг бүрэн олгосон, */Дэлгэрэнгүйг Хүснэгт 8-д харуулав/*
11. Хушаат сум **12.8 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “*Эрчим хүчний шугам татах*” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн,
12. Мандал сум **57.7 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “*Асфальтан замын зураг, төсөв хийлгэх*” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг үнэлгээний хуудсаар үнэлээгүй,
13. Сүхбаатар сум устгасан нохойны тоо толгойг нотлох нягтлан бодох бүртгэлийн анхан шатны, дэмжих баримтгүйгээр ИЗЗИ компанид 1900 нохой устгасан гэж **20.0 сая төгрөгийг** шилжүүлсэн байна.

Хоёр. Зөвлөмж:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн **59.0 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “*Усан бассейны дулааны шугамын ажил*”, **45.6 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй “*Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах*” 2 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй,
2. 4 сум худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан нийт **70.8 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй дараах төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй,
3. 7 сум шууд худалдан авах аргаар хэрэгжсэн нийт **104.7 сая төгрөгийн** төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч ЗДТГ-аас хяналт

хийгээгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 7-д харуулав/

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.
2. 3 сумын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт төвлөрөх 8.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
3. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний жагсаалтыг орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж батлаагүй байна.
4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг гаргаж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн санал авч, эрэмбэлэх ажил бүрэн хийгдэхгүй байна.
5. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтад иргэдээс санал аваагүй 969.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
6. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөв, ТЭЗҮ, магадлал хийгдээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлдэг зөрчил оршсоор байна.
7. Аймгийн ОНХС-гаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн засварын зардалд хөрөнгө хуваарилж, хэрэгжүүлсэн байна.
8. Сумдууд худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулахдаа зарим тендерт 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал хүргүүлээгүй бөгөөд үнэлгээний хуудсаар үнэлж баримтжуулаагүй байна.
9. ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн болон зураг, төсөв зохиогчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
10. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй байна.
11. ОНХС-ийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.
12. Аймаг болон сумдууд ОНХС-ийн хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.
13. Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлээгүй байна.
14. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээллийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд Шилэн дансанд мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад:

1. Хяналтын хорооноос ОНХС-ийн хэрэгжилтийг шалгасан эсэхэд хяналт тавьж, тайлан, үр дүнг хэлэлцэж байх.

2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр өргөн мэдүүлж буй төсөл, арга хэмжээ нь зориулалтын дагуу байгаа эсэх, иргэдийн саналаар баталгаажсан эсэх, зураг төсөв, ТЭЗҮ нь хийгдсэн эсэхийг хянаж, баталж байх.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан, эрэмбэлэх.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ажиллах.
3. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөж, батлуулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг санхүүжүүлэхгүй байх.
4. Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг зааврын дагуу ажиллуулж, тайланг хэлэлцэж байх.
5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг ТЭЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар гүйцэтгүүлж, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлэх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.
2. ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд тавигдах захиалагчийн хяналтыг сайжруулж, зураг, төсөв зохиогчийн хяналтын тайлан, дүгнэлт зэрэг холбогдох баримт материалыг үндэслэн санхүүжилт олгож байх.
3. ОНХС-ийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тухай бүр тогтоож, аймгийн ОНӨГ-тай хамтран бүртгэлд тусгуулж байх.

Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороогоор гүйцэтгүүлж, дүнг хэлэлцэж байх.
2. Багийн ИНХ-аас ирүүлсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх ажлыг журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналаар дэмжигдээгүй, ТЭЗҮ, зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй ажлыг тусгаж, батлуулахгүй байх.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих
5. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавигдах захиалагчийн хяналтыг сайжруулж, зураг төсөв зохиогчийн хяналтын тайлан, дүгнэлт зэрэг холбогдох баримт материалыг үндэслэн санхүүжилтийг олгож байх.
6. Ерөө, Сайхан, Түшиг сумд 2013 оноос үүссэн 8.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах.
7. Дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээг гүйцээж, ашиглалтад оруулах.

Бүлэг 2

СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс сангийн эх үүсвэрийн 73.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн хэлбэрт шилжсэн байна.

2.1. СХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгээс орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, төлөвлөсөн орлогын 39.3 хувийг төвлөрүүлсэн байна.

2.1.1. СХС-ийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн үү?

Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги тооцож, орлого төвлөрүүлээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 2.1-д улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, буцалтгүй тусламж, сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги зэрэг орлогоос сангийн хөрөнгийг бүрдүүлэхээр заасан байдаг.

2017 онд аймгийн хэмжээний 17 сумын Сум хөгжүүлэх санд дээр дурдсан эх үүсвэрүүдээс зөвхөн 2-оос нь буюу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгээс орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, бүрдүүлсэн бол гэрээнд заасны дагуу хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги тооцож, орлого бүрдүүлэхээр төлөвлөөгүй байна.

Зүүнбүрэн, Орхон, Мандал, Сүхбаатар, Хушаат, Шаамар зэрэг 6 сумд “Сум хөгжүүлэх сан”-гийн орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож батлаагүй байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3⁴² дахь заалтыг зөрчсөн байна.

2017 онд аймгийн хэмжээний нийт сумдын дүнгээр зээлийн эргэн төлөлт болон зээлийн хүүгийн орлогоос нийт 1,780.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч эргэн төлөлтөөс 656.6 сая төгрөгийн, хүүгээс 43.6 сая төгрөгийн

⁴² Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 3.3.1. сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох.

зэрэг нийт 700.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээр орлогын төлөвлөгөө 39.3 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл болон оны эхний, эцсийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9 /сая төгрөг/

Д/д	Сумд	СХС-ийн өмнөх оны үлдэгдэл	Нийт төлөвлөлт	Гүйцэтгэл			Гүйцэтгэл ийн хувь	СХС-ийн эцсийн үлдэгдэл
				Зээлийн эргэн төлөлтөөс	Хүүгээс	Нийт		
1	Алтанбулаг	42.0	78.4	49.0	1.0	50.0	63.8	92.0
2	Баруунбүрэн	10.4	141.1	38.8	0.3	39.1	27.7	49.5
3	Баянгол	53.1	80.8	43.0	2.0	45.0	55.7	98.1
4	Ерөө	2.6	77.0	25.8	4.4	30.2	39.2	32.8
5	Жавхлант	5.5	41.2	17.2	7.4	24.6	59.7	30.1
6	Зүүнбүрэн	20.1	139.0	18.7	0.5	19.2	13.8	39.3
7	Мандал	20.0	147.8	62.5	6.0	68.5	46.3	88.5
8	Орхон	54.1	211.2	39.9	0.4	40.3	19.1	94.4
9	Орхонтуул	11.0	62.6	19.6	-	19.6	31.3	30.6
10	Сант	3.3	62.1	50.6	1.7	52.3	84.2	55.6
11	Сайхан	25.2	86.0	58.5	5.1	63.6	74.0	88.8
12	Сүхбаатар	40.6	32.6	117.4	5.6	123.0	377.3	163.6
13	Хушаат	10.7	159.6	13.3	0.1	13.4	8.4	24.1
14	Хүдэр	33.7	87.1	30.4	1.1	31.5	36.2	65.2
15	Түшиг	1.5	108.3	23.7	2.7	26.4	24.4	27.9
16	Цагааннуур	9.8	64.9	30.8	4.8	35.6	54.9	45.4
17	Шаамар	2.2	200.9	17.4	0.5	17.9	8.9	20.1
	Нийт дүн	345.8	1,780.6	656.6	43.6	700.2	39.3	1,046.0

Хүснэгтээс харахад Хушаат, Шаамар, Зүүнбүрэн, Орхон, Түшиг, Хүдэр, Жавхлант, Орхонтуул сумд төлөвлөсөн орлогын 8,9-31,3 хувийг төвлөрүүлсэн бол Алтанбулаг, Сайхан, сумд 63,8- 74,0 хувийг, Сүхбаатар сум 3 дахин давуулан биелүүлж, төвлөрүүлсэн байна.

Сумдууд ирэх онд зээлийн эргэн төлөлтөөс төвлөрөх ёстой орлогын дүнд үндэслэн сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг төлөвлөсөн боловч зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс төлөвлөсөн орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Тайлант онд Зүүнбүрэн, Орхон, Мандал, Сүхбаатар, Хушаат, Шаамар зэрэг 6 сумын ИТХ нь СХС-ийн орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож батлаагүй байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3⁴³ дахь заалтыг зөрчсөн байна.

Цаашид сумдын ИТХ нь СХС-ийн орлого, зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

⁴³ Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 3.3.1. сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох.

2.1.2 Зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүү, алдангийг бүрэн төвлөрүүлсэн үү?

Зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөвлөсөн орлогын 39.3 хувийг төвлөрүүлсэн бөгөөд 123.9 сая төгрөгийн алдангийн орлого олох боломжийг алдсан байна.

Сумдууд тус сангаас 2017 оноос өмнө олгосон зээлийн жилийн хүүг 1-3 хувийн хооронд тооцож төвлөрүүлэхээр зээлийн гэрээнд тусгасан бөгөөд аудитын явцад зээлийн хүүгийн орлогыг тулган баталгаажуулахад төлөвлөсөн зээлийн хүүгийн орлогын 9.3 хувь буюу 43.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 423.5 сая төгрөгөөр дутуу байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10 /сая төгрөг/

Д/д	Сумд	Хүүгийн орлого		
		Төвлөрүүл бэл зохих	Төвлөрүү лсэн	Гүйцэтгэл ийн хувь
1	Алтанбулаг	21.9	1.0	4.6
2	Баруунбүрэн	16.1	0.3	1.9
3	Баянгол	22.0	2.0	9.1
4	Ерөө	23.1	4.4	19.1
5	Жавхлант	17.9	7.4	41.2
6	Зүүнбүрэн	7.9	0.5	6.4
7	Мандал	75.3	6.0	8.0
8	Орхон	18.2	0.4	2.2
9	Орхонтуул	27.0	0.0	0.0
10	Сант	13.4	1.7	12.7
11	Сайхан	41.0	5.1	12.4
12	Сүхбаатар	112.5	5.6	5.0
13	Хушаат	8.8	0.1	0.7
14	Хүдэр	9.5	1.1	11.6
15	Түшиг	11.9	2.7	22.7
16	Цагааннуур	23.1	4.8	20.8
17	Шаамар	17.5	0.5	2.9
Нийт дүн		467.1	43.6	9.3

Сумдууд нийтлэг байдлаар зээлийн эргэн төлөлтөөс хуримтлагдсан хүүг эхэлж тооцож авалгүйгээр үндсэн зээлээс хасалт хийж байгаа нь хүүгийн авлага нэмэгдэж, орлого буурах эрсдэлийг үүсгэж байна.

Журмын 1.7⁴⁴-д заасны дагуу гэрээний хугацаа хэтэрсэн зээлд алданги ногдуулахаар журамлагдсан атал, тооцож, ногдуулаагүйгээс нийт сумдын дүнгээр 123.9 сая төгрөгийн алдангийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

⁴⁴ Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана.

Хүснэгт 11 /сая төгрөг/

Д/д	Сумд	Зээлийг бүрэн төлж дуусах хугацаа болсон		Гэрээнд заасан алданги тооцох хувь	Аудитаар тооцсон алданги
		Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн		
1	Алтанбулаг	28	127.6	сарын 0.2%	2.8
2	Баруунбүрэн	31	80.7	сарын 0.3%	2.9
3	Баянгол	18	197	сарын 0.5%	15.7
4	Ерөө	51	138.1	хүүний 20%	1.8
5	Жавхлант	37	122.8	сарын 0.05%	1.5
6	Зүүнбүрэн	69	107.8	сард төлөх үндсэн зээлийн төлбөрийн 10 %	9.1
7	Мандал	32	700.9	сарын 0.05%	4.6
8	Орхон	22	36.2	сарын 3%	1.6
9	Орхонтуул	33	160.9	сарын 0.016%	1.3
10	Сант	27	91.4	2011 онд сарын 0.3%, 2013 оноос хойш сарын 0.5 %	4.2
11	Сайхан	78	277	сарын 0.3 %	11.4
12	Сүхбаатар	92	275.8	хугацаа заагаагүй, төлөгдөөгүй зээлийн үлдэгдлээс 10%	26.1
13	Хушаат	39	135.4	сарын 0.5%	7.1
14	Хүдэр	43	87.1	сарын 0.25-0.5%	4.1
15	Түшиг	54	124.5	2011 онд сарын 0.2%, 2013 оноос хойш сарын 0.3 %	22.9
16	Цагааннуур	28	89.6	сарын 1%	5.2
17	Шаамар	52	173.7	сарын 0.05%	1.6
Нийт дүн		734	2,926.5		123.9

Дээрх хүснэгтээс харахад өмнөх жилүүдэд олгосон зээлийн гэрээнд алданги тооцох хувь, хэмжээг харилцан адилгүй тусгаж ирсэн бол 2017 онд олгосон зээлийн гэрээнд төлөгдөөгүй зээлийн хоног тутамд 0.5 хувийн алданги төлөхөөр тусгасан байна.

2.2. СХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

СХС-ийн хөрөнгийг ижил чиглэлийн олон үйл ажиллагаанд хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөхөд үр нөлөө үзүүлэхгүй байна.

2.2.1. СХС-аас зээл олгох төсөл, хөтөлбөрийг журамд нийцүүлэн сонгон шалгаруулж байна уу?

Сумдын сонгон шалгаруулах зөвлөл нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлийг хугацаанд нь төлөх төлбөрийн чадварыг бодитоор үнэлээгүй байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11⁴⁵ дэх заалтын дагуу 2017 оны байдлаар нийт эх үүсвэрийн 20 хувийг нөхөн бүрдүүлээгүйн улмаас Сэлэнгэ аймгийн 17 сумаас 11 сум нь нийт 86 төсөлд 491,6 сая төгрөгийн зээл олгож, бусад 6 сум зээл олгоогүй байна.

Тайлант онд зээл олгохоор дэмжигдсэн нийт төслийн 30.2 хувь нь шинээр үйл ажиллагаа эхлэхэд, 69.8 хувь нь үйл ажиллагаагаа өргөтгөхөд чиглэсэн бөгөөд эргэлтийн хөрөнгө бэлтгэхэд 47.7 хувийг, тоног төхөөрөмж авахад 32.6 хувийг, машин техник худалдан авах, барилга барихад 3.5 хувийг, үндсэн хөрөнгө бэлтгэхэд болон бусад зориулалтаар 15.1 хувийг тус тус зарцуулахаар төсөл ирүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12 / сая төгрөг/

Ерөнхий мэдээлэл			Зээлийн зориулалт								ЖДҮ						
Д/д	Сумд	Нийт олгосон зээл		Эргэлтийн хөрөнгө		Тоног төхөөрөмж		Машин техник, барилга		Үндсэн хөрөнгө бусад		Ажлын хөлс		Шинээр байгуулсан		Өргөтгөсөн	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	3	28.0	1	14.0	1	5.0			1	9.0			1	9.0	2	19.0
2	Баруунбүрэн	13	42.0	7	22.0	5	17.0			1	3.0			4	12.0	9	30.0
3	Баянгол	5	77.0	2	16.0	1	6.0	1	30.0	1	25.0			1	25.0	4	52.0
4	Зүүнбүрэн	4	21.0	2	6.0	1	5.0			1	10.0					4	21.0
5	Орхон	10	75.0	4	23.0	3	23.0	1	5.0	2	24.0			4	32.0	6	43.0
6	Орхонтуул	1	4.6			1	4.6							1	4.6		
7	Сайхан	19	85.0	5	15.5	7	29.5			6	30.0	1	10.0	6	30.5	13	54.5
8	Сант	10	47.5	6	26.5	3	11.0	1	10.0					4	15.0	6	32.5
9	Сүхбаатар	4	60.0	4	60.0									2	30.0	2	30.0
10	Хүдэр	12	43.0	6	23.0	5	16.0			1	4.0			2	7.0	10	36.0
11	Шаамар	5	8.5	4	2.0	1	6.5							1	6.5	4	2.0
Нийт дүн		86	491.6	41	208.0	28	123.6	3	45.0	13	105.0	1	10.0	26	171.6	60	320.0
Дүн хувиар		100	100	47.7	42.3	32.6	25.1	3.5	9.2	15.1	21.4	1.2	2.0	30.2	34.9	69.8	65.1

Олгосон зээлийг салбараар нь ангилж үзвэл хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд 24.4 хувийг, үйлчилгээний чиглэлд 19.8 хувийг, мал аж ахуйн чиглэлд 17.4 хувийг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд 9.3 хувийг, газар тариалангийн чиглэлд 8.1 хувийг, барилгын чиглэлд 7.0 хувийг, худалдааны чиглэлд 5.8 хувийг, бусад чиглэлд 8.1 хувийг олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 13 / сая төгрөг/

⁴⁵ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Д/д	Сумд	Нийт олгосон зээл		Хүнсний үйлдвэр		Хөнгөн үйлдвэр		Газар тариалан		Мал аж ахуй		Барилга		Худалдаа		Үйлчилгээ		Бусад	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	3	28.0					1	14.0							1	5.0	1	9.0
2	Баруунбүрэн	13	42.0	5	16.0					2	6.0	1	3.0			4	14.0	1	3.0
3	Баянгол	5	77.0							1	25.0			1	15.0	2	7.0	1	30.0
4	Зүүнбүрэн	4	21.0	1	5.0			1	3.5	1	2.5					1	10.0		
5	Орхон	10	75.0	2	19.0			3	10.0	3	37.0	2	9.0						
6	Орхонтуул	1	4.6	1	4.6														
7	Сайхан	19	85.0	5	16.5	2	13.0			5	20.0	3	11.0	1	1.5	2	13.0	1	10.0
8	Сант	10	47.5	2	7.0	1	4.0			3	13.5					3	13.0	1	10.0
9	Сүхбаатар	4	60.0					2	35.0					1	15.0			1	10.0
10	Хүдэр	12	43.0	1	4.0	4	12.0							2	7.0	3	13.0	2	7.0
11	Шаамар	5	8.5	4	2.0	1	6.5												
Нийт дүн		86	491.6	21	74.1	8	35.5	7	62.5	15	104.0	6	23.0	5	38.5	17	85.0	7	69.0
Дүн хувиар		100	100	24.4	15.1	9.3	7.2	8.1	12.7	17.4	21.2	7.0	4.7	5.8	7.8	19.8	17.3	8.1	14.0

Хүснэгтээс харахад нийт 63 төсөлд 1.0-5.0 хүртэлх сая төгрөгийн зээл олгосон байгаа нь нийт зээлийн 73.2 хувийг эзэлж байна.

Ингэж СХС-ийн зээлийг хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрийг дэмжих, тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх гэхээсээ илүү иргэдийн өдөр тутмын амьжиргаанд зориулан олгож байгаа мэт харагдаж, зээлийн үр дүн, үр өгөөжийг бууруулж байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3⁴⁶-д заасны дагуу сумын ИТХ-ын тогтоолоор төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг томилж, ажиллуулахаар зохицуулагдсан байдаг.

2017 онд СХС-аас зээл олгох төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумдын ИТХ-ын тогтоолоор Засаг даргаар ахлуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсон байна.

Бүх сумд дээрх орон тооны бус зөвлөлд баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг багийн ИНХ-аар хэлэлцүүлж сонгоогүй байгаа нь СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.4.1⁴⁷ дэх заалтыг зөрчсөн байна.

Орхонтуул сумаас бусад сумдын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 8.1⁴⁸ дэх ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Хэдийгээр зөвлөлийн шийдвэрийг хурлын тэмдэглэлээр баталгаажуулж байгаа ч ихэнх сумдын хурлын тэмдэглэл гишүүдийн гарын үсгээр бүрэн баталгаажуулж, хурлыг зөвхөн шалгарсан төслийг хэлэлцэх хүрээнд хийсэн бөгөөд иргэдээс төсөл хүлээн авч, хариу өгсөн тухай бүртгэл хөтлөөгүй, шалгараагүй төслийн үндэслэлийг тодорхойлж албан ёсоор хариу мэдэгдээгүй зэрэг зөрчил нийтлэг байдлаар оршиж байна.

⁴⁶ Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИТХ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 3.3.3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах

⁴⁷ Зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцэн сонгосон байх
⁴⁸ 8.1. Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 4.2⁴⁹-т заасан шаардлагыг хангасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, хуулийн этгээдэд журмын 4.3⁵⁰-т заасан шалгуурт нийцсэн төслийг сонгон шалгаруулахаар зохицуулсан байдаг.

Аудитын явцад төслийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт материал, зээлдэгчдийн хувийн хэргийг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Алтанбулаг сум 1, Хүдэр сум 1 зэрэг нийт 2 зээлдэгчид багийн Засаг даргын тодорхойлолт хийгдээгүй, тухайн сумын оршин суугч мөн эсэхийг нотлох баримтгүйгээр зээл олгох шийдвэр гаргасан.
- Хүдэр сум 1 зээлдэгчийн хувийн хэрэгт ирүүлсэн төслийг хавсаргаагүй, ямар төслийг сонгон шалгаруулсан нь тодорхойгүй байна.
- Хүдэр сум 2 зээлдэгчийн хувийн хэрэгт банкны өргүйг нотолсон тодорхойлолт, лавлагааг хавсаргаагүй байна.

Журмын 4.2.2⁵¹ -т заасан шалгуурыг Сант сум 2013 оноос эхлэн мөрдөж, сумын ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн, татварын байцаагч, санхүүгийн албаны дарга болон суманд байрлалтай бүх банкуудыг хамруулан тойрох хуудсаар баримтжуулж байгаа бол бусад сумд уг шалгуурыг харгалзаж үзээгүй байна.

Бүх сумдын сонгон шалгаруулах зөвлөл нь төсөл ирүүлсэн иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай эсэхийг бодитой үнэлээгүй, орлогын эх үүсвэрийг зөвхөн 1-2 банкны өргүй эсэх тухай тодорхойлолтыг үндэслэн шийдвэрлэж байгаа нь зээлийн ашиглалт, эргэн төлөлт хангалтгүй байх нэг үндэс болж байна.

Сумдууд жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйл ажиллагааг нь өргөтгөхөд тэргүүлэх чиглэлийг баталж, энэ чиглэлээр зээл олгосон бол Сайхан сум нь сангийн зорилгод нийцээгүй 1 удаагийн шинжтэй хөрөнгө оруулалтын чиглэлээр иргэн Ж.Цогмаагийн хувийн цэцэрлэгийн хашааг барих төслийг шалгаруулж, 10.0 сая сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн байна.

2.2.2. Зээлийн гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрээний заалтыг мөрдөж байна уу?

Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хугацаандаа төлөгдөхгүй байх зэргээр гэрээний зарим зүйл, заалт хэрэгжээгүй байна.

Журмын 2-р хавсралтаар “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг баталсан байдаг.

⁴⁹ Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна: 4.2.1. тухайн суманд бүртгэлтэй буюу оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх, 4.2.2. сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх, 4.2.3. зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх, 4.2.4. жижиг, дунд үйлдвэр эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх (түүнийг нотлох баримт бичиг шаардлагатай)

⁵⁰ Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл дараах шаардлагыг хангасан байна: 4.3.1. тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх, 4.3.2. төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой байх, 4.3.3. гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх, 4.3.4. төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх, 4.3.5. төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх, 4.3.6. ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

⁵¹ Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

Сумдууд зээлийн гэрээг баталсан загварын дагуу байгуулсан боловч гэрээний эрх үүргийн биелэлт хангалтгүй, хариуцлага сул байгаагаас үндсэн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, хүүгийн эргэн төлөлт хангалтгүй, алданги тооцож барагдуулаагүй зэрэг гэрээний гол заалтууд хэрэгжээгүй байна.

2017 оны байдлаар аймгийн дүнгээр нийт 5038,0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрийн 1610,8 сая төгрөгийн зээл хэвийн, 500,7 сая төгрөгийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, 2,926.5 сая төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл нийт эх үүсвэрийн 68,0 хувийг чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.

Тайлант онд зээл олгосон 11 сум зээлийн гэрээнд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлдэгчийн харьяалал солигдсон тохиолдолд зээл, зээлийн хүүг хэрхэн бүрэн төлүүлж дуусгах, хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх зэрэг заалтыг гэрээнд тусгаагүй байна.

Хэдийгээр барьцаа хөрөнгийн гэрээ хийж байгаа ч уг гэрээг улсын бүртгэлээр баталгаажуулаагүй, хөдлөх хөрөнгийн / машин техник, мал амьтан, гэрийн тавилга г.м/ эзэмших эрхийг шилжүүлж аваагүй зэрэг зөрчил түгээмэл байгаа нь барьцаалсан хөрөнгүүд бодит байдал дээр барьцаалагдаж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл барьцаалсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрх нь зээл авсан иргэн, аж ахуйн нэгжид хэвээр хадгалагдаж, зээл төлөх хөшүүрэг болж чадахгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт муу байна.

Тайлант онд олгосон зээлийн барьцаа хөрөнгийн 30.6 хувийг барилга, орон сууц, 19.1 хувийг газар өмчлөх эрхийн бичиг, 16.6 хувийг газар эзэмших эрхийн бичиг, 12.1 хувийг гэр ахуйн тавилга хэрэгсэл, 10.8 хувийг мал амьтан, 9.6 хувийг хөдлөх хөрөнгө /ачааны болон суудлын авто машин, мотоцикл, бусад техник хэрэгслүүд/ , 1.3 хувийг таван ханатай гэр эзэлж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 14

Д/д	Сумд	Зээлдэгчийн тоо	Барьцаа хөрөнгийн төрөл /ширхэгээр/									
			Байр орон сууц, барилга	Газар өмчлөх эрх	Газар эзэмших эрх	Хөдлөх хөрөнгө	Мал амьтад		5 ханатай гэр	Гэр ахуйн тавилга хэрэгсэл	Барьцаа хөрөнгө байхгүй	Нийт барьцаа хөрөнгө
							Зээлдэгч	Толгойн тоо				
1	Алтанбулаг	3	4		3	1						8
2	Баруунбүрэн	13		2	2	4	7	279	1			16
3	Баянгол	5	4		3	1	1	325		5		14
4	Зүүнбүрэн	4	5	3		4	2	92		8		22
5	Орхон	10	6	9	7		3	202		6		31
6	Орхонтуул	1	1	1								2
7	Сант	10	7	5	1		4	266				17
8	Сайхан	19	8	6	6	3			1			24
9	Сүхбаатар	4	4									4
10	Хүдэр	12	9	3								12
11	Шаамар	5		1	4	2						7
Нийт дүн		86	48	30	26	15	17	1164	2	19	0	157
Дүн хувиар			30.6	19.1	16.6	9.6	10.8		1.3	12.1	0.0	100.0

Зарим сумдууд СХС-аас зээл олгохдоо итгэмжлэх хийлгэлгүйгээр өөр хүний эзэмшилд байгаа хөрөнгийг барьцаа болгон авсан зөрчил илэрлээ. Тодруулбал:

- Орхон сум иргэн Х.Шинэбаярын “Сүүний үхрийн аж ахуй эрхлэх” төсөлд 15.0 сая төгрөгийн зээл олгохдоо А.Солонгын, иргэн Б.Энхмаагийн “Хүлэмжийн аж ахуй эрхлэх” төсөлд 4.0 сая төгрөгийн зээл олгохдоо Б.Баттулга, Д.Баярмаа нарын хөрөнгийг, иргэн З.Цэнд-Очирын “Блокны үйлдвэр” төсөлд 4.0 сая төгрөгийн зээл олгохдоо Н.Мөнхбаатарын хөрөнгийг,
- Баруунбүрэн сум иргэн Ж.Ууганчимээгийн “Үсчин, гоо сайхан” төсөлд 3.0 сая төгрөгийн зээл олгохдоо А.Саранцэцэгийн хөрөнгийг,
- Сант сум иргэн Д.Энхтөрийн “Модон эдлэл” төсөлд 4.0 сая төгрөгийн зээл олгохдоо Х.Отгонбаярын хөрөнгийг тус тус барьцаанд авсан байна.

Хүдэр сум иргэн Э.Энхтуяагийн “Мужааны цех байгуулах” төслийг шалгаруулж 3.0 сая төгрөгийн зээлийг олгохдоо Э.Угтахбаярын эзэмшилд буй үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэлийг зээлийн хугацаатай адил 3 жилээр хийсэн байгаа нь тухайн зээлдэгч гэрээний хугацаанд зээлээ төлөөгүй тохиолдолд уг итгэмжлэгдсэн барьцаа хөрөнгийг барьцаалагчийн өмчлөлд авч, худалдаалах замаар зээл, зээлийн хүү, алдангийг нөхүүлэх боломжгүй болох эрсдэлтэй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд зээлийн барьцаанд барьцаа болох эрх зүйн чадамжгүй хөрөнгүүдийг авч байгаа нь олгосон зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх үндсэн нөхцөл болж байна.

2.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байна уу? Ажлын байр нэмэгдсэн үү?

СХС-аас олгосон зээлийн 22.7 хувийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.6 -дахь заалтын дагуу 2017 онд 11 сум 86 төсөлд 491.6 сая төгрөгийн зээлийг жилд 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосон байна.

Аудитын явцад зээл олгосон 11 суманд хүрч, зээлдэгчид авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг тулган баталгаажуулахад нийт зээлийн 4.2 хувь буюу 20.5 сая төгрөгийн 6 төслийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа огт явуулаагүй бол 10.8 хувь буюу сая төгрөгийн 53.0 сая төгрөгийн 9 төсөл хэрэгжиж байгаад зогссон, 2.0 хувь буюу нэг удаагийн шинжтэй 10.0 сая төгрөгийн 1 төсөл хэрэгжээд дууссан бол 5.7 хувь буюу 28.0 сая төгрөгийн 5 төсөл түр зогссон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 15 /сая төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Зээлдэгч ийн тоо	Мөнгөн дүн	Эзлэх хувь
1	Хэрэгжиж байгаа төсөл	65	380.1	77.3
2	Үйл ажиллагаа нь түр зогссон	5	28.0	5.7
3	Нэг удаагийн шинжтэй хэрэгжээд дууссан	1	10.0	2.0
4	үйл ажиллагаагаа явуулж байгаад зогссон	9	53.0	10.8
5	Зээлийг огт ашиглаагүй, зориулалт бусаар зарцуулсан	6	20.5	4.2
Нийт дүн		86	491.6	100

Аудитын явцад зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдлыг газар дээр нь очиж тулган баталгаажуулахад үйл ажиллагаа нь тогтмолжиж, гэрээний дагуу зээлээ хугацаанд төлж байгаа дараах зээлдэгчид байна. Үүнд:

- Баянгол сумын иргэн Б.Энхбат “Хүнд машин механизмийн үйлчилгээ үзүүлэх” төсөл 30.0 сая төгрөгийн, Б.Довдонбат “Үнээний ферм байгуулах” төсөл 25.0 сая төгрөгийн, Л.Өлзийсайхан “Тохилог орчин” төсөл 15.0 сая төгрөгийн,
- Сайхан сумын иргэн О.Чинбат “Гутлын үйлдвэр байгуулах” 10.0 сая төгрөгийн, Д.Юмсүрэн “Эмийн сан байгуулах” төсөл 10.0 сая төгрөгийн, Б.Сувданчимэгийн “Гоо сайхны салон өргөжүүлэх” төсөл 3.0 сая төгрөгийн,
- Зүүнбүрэн сумын иргэн Б.Цолмон “Хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлэх” төсөл 10.0 сая төгрөгийн, Л.Саранцэцэгийн “Эрчимжсэн мах, сүүний ферм байгуулах” төсөл 14.0 сая төгрөгийн,
- Орхон сумын иргэн Т.Амартүвшин “Хөрөө рамм байгуулах” төсөл 10.0 сая төгрөгийн,
- Хүдэр сумын иргэн Ч.Ариунаа “Оёдлын цех байгуулах”, Б.Мягмар “Гэрийн мод бэлтгэх” төслүүд тус бүр 3.0 сая төгрөгийн, Б.Амгаланзаяа “Фитнесс төв байгуулах”, Б.Нарангараев “Барилгын материалын дэлгүүр байгуулах” , Б.Бүжинлхам “Засвар үйлчилгээ эрхлэх” төслүүд тус бүр 4.0 сая төгрөгийн зээл зэрэг болно.

Харин Сант сумын иргэн Б.Наранцэцэгийн “Гахайн аж ахуй” төсөлд олгосон 1.5 сая төгрөгийн, Ж.Оюунгэрэлийн “Зөгийн аж ахуй” төсөлд олгосон 2.0 сая төгрөгийн, Б.Алтанцэцэгийн “Гахайн аж ахуй” төсөлд олгосон 4.0 сая төгрөгийн, Орхон сумын иргэн Ц.Шархүүгийн “Блокны үйлдвэрлэл” төсөлд олгосон 5.0 сая төгрөгийн, Хүдэр сумын иргэн Ц.Мөнхцэцэгийн “Хими цэвэрлэгээ”, Ж.Отгонхүүгийн “Гахайн мах, махан бүтээгдэхүүн уутлах” төслүүдэд тус бүр 4.0 сая төгрөгийн зэрэг нийт 20.5 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа огт явуулаагүй байна.

Зээл авсан боловч өнөөгийн байдлаар үйл ажиллагаа нь зогссон дараах 9 зээлдэгч байна. Үүнд:

- Орхон сумын иргэн Г.Саранзаяа “Амтлаг талхны цех байгуулах” төсөл 3.0 сая төгрөг, З.Цэнд-Очир “Блокны үйлдвэр байгуулах” төсөл 4.0 сая төгрөг, А.Баянмөнх “Махны үхрийн ферм” төсөл 13.0 сая төгрөг,
- Сант сумын иргэн Л.Бямбадоржийн “Эрчимжсэн мал, аж ахуй” төсөл 10.0 сая төгрөг, Д.Цэцгээ “Оёдлын цех” төсөл 6.0 сая төгрөг,
- Сайхан сумын иргэн С.Ганбаатар “Сүүний цех байгуулах” төсөл 4.0 сая төгрөг, Л.Цогоо “Гахайн аж ахуй байгуулах” төсөл 4.0 сая төгрөг,
- Баянгол сумын иргэн Х.Отгонцэцэг “Нийтийн хоол” төсөл 6.0 сая төгрөг,
- Хүдэр сумын иргэн Х.Даваажав “Нэхий, ширэн эдлэл боловсруулах” төсөл 3.0 сая төгрөг зэрэг болно.



Сайхан сум



Хүдэр сум

/Гутлын үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд/

/Оёдлын цех/

Аудитын явцад СХС-ийн зээл олголт, ашиглалтын талаар 14 сумын 111 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдээс санал асуулга авахад 53.1 хувь нь тус сангаас жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр зээл олгодог гэдгийг мэддэг бол 59.5 хувь нь тус сангийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч чадахгүй байна. Оролцогчдын 57.6 хувь нь тус сангийн тухай мэдээллийг нутгийн иргэд болон орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээс авдаг, сантай холбоотой хууль, журмыг 55.8 хувь нь судалж үзээгүй гэсэн бол 63.0 хувь нь тус сангаас зээл авч байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна. Санал асуулгын дүнгээс харахад иргэдийн тус сангийн талаарх мэдээлэл дутмаг, төслийн сонгон шалгаруулалт, зээл олголт ил тод байдлыг хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Тайлант онд иргэдийн ирүүлсэн төслийн үр дүнд 202 ажлын байр бий болгохоос 155 ажлын байр бий болж, 76.7 хувьтай хэрэгжсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 16

Д/д	Сумд	Сонгон шалгаруулсан нийт төслийн тоо	Шинээр бий болгохоор төлөвлөсөн ажлын байрны тоо	Шинээр бий болгосон ажлын байрны тоо			
				Нийт	Үүнээс:		Одоо ажиллаж байгаа
					Байнгын	Түр	
1	Алтанбулаг	3	5	4	4		4
2	Баруунбүрэн	13	22	18	13	5	18
3	Баянгол	5	20	15	15		15
4	Зүүнбүрэн	4	13	11	8	3	11
5	Орхон	10	24	17	11	6	17
6	Орхонтуул	1	2	2	1	1	2
7	Сант	10	25	20	12	8	20
8	Сайхан	19	48	30	22	8	30
9	Сүхбаатар	4	8	8	8	0	8
10	Хүдэр	12	23	20	16	4	20
11	Шаамар	5	12	10	8	2	10
Нийт дүн		86	202	155	118	37	155

Хүснэгтээс харахад 2017 онд шалгаруулсан 86 төслийн үр дүнд 155 ажлын байр шинээр бий болсны 118 нь байнгын, 37 нь түр ажлын байр байна.

2.3. СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнасан уу?

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо сул, зарим сумдын санхүүгийн тайлан үнэн зөв тайлагнагдаагүй байна.

2.3.1. Орон нутгийн болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтнууд хууль журамд заасан эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу? СХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Журамд СХС-ийн удирдлага, зохион байгуулалтыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй аймгийн ХХААГ болон тус санг хариуцсан мэргэжилтнүүдийн эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалт тусгагдаагүй байна. СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт шалгалт үр нөлөө муутай байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах хяналт тавих журам”-ын 3 дугаар бүлэгт тус сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга /ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгж/ хэрэгжүүлэхээр эрх, үүргийг нь баталж өгсөн байна.

Гэвч яамдын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 2017 оны 04 дүгээр сараас СХС-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн аймгийн ХХААГ-т шилжиж, тус сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сан байгуулагдсан 2011 оноос хойш СХС-ийн асуудлыг 3 яаманд /ХХААЯ, Хөдөлмөрийн яам, Аж үйлдвэрийн яам/ ээлжлэн шилжүүлснээр аймагт Хөдөлмөрийн хэлтэс, аймгийн Засаг дарга, ХХААГ, сумдад 2011-2013 оны 04 сар хүртэл ХАА-н тасгийн мэргэжилтэн, 2013 оны 04 сараас 2017 оны 04 сар хүртэл хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2017 оны 04 сараас ХАА-н тасгийн мэргэжилтэн /дарга/ хариуцаж ирсэн байна.

Аймгийн ХХААГ-аас журмын хэрэгжилтийг хангахын тулд сумдад аймгийн Засаг даргын албан бичиг даалгавар хүргүүлэх, хяналт шалгалт хийх, зөвлөмж хүргүүлэх зэрэг ажлыг хийж ирсэн ч сангийн журамд эрх үүрэг нь тодорхой бус байгаагаас сумдын холбогдох албан тушаалтнуудаас зөвлөмжийн хэрэгжилтийг шаардах, хариуцлага тооцох зэрэг эрх зүйн чадамжгүй байна.

Аудитын дүнгээс харахад сумын ИТХ-аас сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх ажил хангалтгүй байна.

Харин зээл, зээлийн хүүгийн дээд хэмжээ, сонгон шалгаруулах болон хяналтын зөвлөлийг батлах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг дарга сангийн үйл ажиллагаанд оролцох 9 чиг үүргийг журмаар баталж өгснөөс сонгон шалгаруулах зөвлөлийг ахлах, зээл олгох шийдвэрийг гаргах 2 чиг үүргийг хэрэгжүүлж, бусад 7 чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- Төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах;
- Төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах;
- Зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаанд барцуулах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх;
- Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;
- сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах;

- *Сумын иргэн, хуулийн этгээдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх болон бусад шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх саналаа аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх, иргэдийн дунд сургалт зохион байгуулж, оролцоог хангаж ажиллах.*

Үүнээс үзэхэд аймгийн хэмжээнд СХС-ийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, хариуцлага тооцох төрийн захиргааны байгууллагуудын оролцоог тодорхой болгон журамлаж өгөх шаардлагатай байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад ИТХ-аас баталсан орон тооны бус хяналтын зөвлөл, тухайн сумын иргэд, мэргэжлийн байгууллагаар хяналт хийлгэхээр зохицуулагдсан байдаг.

Аудитын дүнгээс харахад сангийн үйл ажиллагаанд иргэдийн зүгээс хяналт тавиагүй бол аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Шаамар, Зүүнбүрэн, Түшиг сумдад хяналт шалгалт хийж авлагын үлдэгдэл их байгааг барагдуулан ажиллах зөвлөмж өгсөн байна.

СХС-аас зээл олгож эхэлснээс хойш Баянгол, Зүүнбүрэн, Мандал, Сант, Цагааннуур, Сайхан, Жавхлант, Хушаат, Хүдэр, Алтанбулаг, Сүхбаатар сумын хяналтын зөвлөлөөс 1-6 удаа хяналт хийж, дүнг сумын ИТХ болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, зээлдэгч нарт хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах мэдэгдэл өгөх, хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч иржээ.

Харин дээрхээс бусад 7 сум /Баруунбүрэн, Ерөө, Орхон, Орхонтуул, Шаамар, Цагааннуур, Түшиг/-ын хяналтын зөвлөл хяналт шалгалт огт хийгээгүй, сумын иргэдийг мэдээллээр хангаагүй байна.

2015, 2016 онуудад Аж үйлдвэрийн яамнаас СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд шалгалт хийж, 2016 оны 04-р сарын 20-ны өдөр сумдад 13 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн боловч дараах 5 заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- *Санхүүгийн тайлан, мэдээг хууль тогтоомжийн дагуу хөтөлж ажиллах, шаардлага хангахгүй, зөрүүтэй тооцоолол, алдаатай байгаа тоог засах,*
- *Төслийг сонгон шалгаруулахдаа шалгуур үзүүлэлтийг баримталж зах зээлийн эрсдэлийг судалж, төсөл бүрт үнэлгээ өгч байх,*
- *Шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй зээлдэгчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан төлүүлэх бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбогдон гарах зардал, шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын асуудлыг зээлдэгч бүрэн хариуцаж төлөх зохицуулалтыг гэрээнд нэмж тусгах,*
- *Хугацаа хэтрэлттэй, эргэн төлөлтгүй зээлийн талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавих. Зээлийн хугацаа дууссан төлөөгүй зээлдэгчдийг яаралтай шүүхэд шилжүүлэх, Сум хөгжүүлэх санг хохиролгүй болгох арга хэмжээ авах,*
- *Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн зохицуулалтыг мөрдөж ажиллах. Зөвлөлийн гишүүний хамаарал бүхий этгээд төсөл ирүүлсэн тохиолдолд уг төсөлд санал өгөх эрхээс татгалзаж энэ тухай тэмдэглэл үйлдэх.*

Дээрхээс үзэхэд СХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт хангалтгүй, үр дүн муу байгаагаас зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт хангалтгүй, сангийн үйл ажиллагаа үр дүн муутай байна гэж дүгнэж байна.

2.3.2. Сангийн хөрөнгийн бүртгэл тайлагнал бодитой байна уу?

СХС-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.5.6 , 5.4 , 5.5 -т заасны дагуу сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргах, сангийн орлого, зарлагын мэдээ тайланг улирал, жилээр гаргаж, ИТХ-д тайлагнах, жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр тусгасан байна.

Гэвч тус журамд аймгийн ХХААГ-ын болон сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн, сангийн нягтлан бодох бүртгэл хариуцах ажилтнуудын эрх, үүргийн талаар огт тусгаагүй байгаагаас сангийн санхүүгийн тайланг тусгайлан сумын ИТХ-д тайлагнадаггүй, аймгийн ХХААГ сумдаас сар бүр мэдээ авч нэгтгэн ХХААХҮЯ-д хүргүүлдэг ч мэдээний үнэн зөв, бодитой эсэхэд хяналт тавьдаггүй байна.

Өнөөгийн байдлаар зээл олголт, эргэн төлөлт, хүү тооцоолол зэрэг анхан шатны бүртгэл хөтлөлтийг сум хөгжүүлэх сан хариуцсан ХАА-ийн тасгийн мэргэжилтэн хийж байгаа бөгөөд санхүүгийн тайланг ЗДТГ-ын нягтлан бодогч нар гаргаж байна.

2018 оноос өмнө сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн буюу зээл, зээлийн хүү, алдангийг тооцоолох, бүртгэх нэгдсэн заавар чиглэл байхгүй байснаас тус сан хариуцсан ажилтнууд өөрсдийн зохиосон хүснэгтээр, өөр өөрөөр бүртгэл хөтөлж байсан нь иргэдээс зээлийн хүүг илүү, дутуу тооцоолж авах, зээлийг бүрэн төлж дуусаагүй байхад хаах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг зөрчлүүд нийтлэг байдлаар оршиж байна. Тухайлбал дараах 4 сумын СХС хариуцсан ХАА-н тасгийн мэргэжилтний зээл, зээлийн хүүгийн авлагын тооцоолол нь санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн авлагаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 17 /сая төгрөг/

Д/д	Сумд	Санхүүгийн тайлан	Сан хариуцсан мэргэжилтний тооцоо	Санхүүгийн тайланд илүү, дутуу илэрхийлэгдсэн дүн	
				Илүү	Дутуу
1	Алтанбулаг	214.3	238.5		24.2
2	Жавхлант	159.1	169.8		10.7
3	Түшиг	187.8	171.5	16.3	
4	Хушаат	157.5	141.6	15.9	
Нийт дүн		718.7	721.4	32.2	34.9

2.3.3 Зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа барагдуулаагүй, төсөл хөтөлбөрийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцож байна уу?

Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцоогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 6 дугаар бүлэгт заасан хариуцлагын тогтолцооноос зээлээ хугацаанд нь төлөөгүй зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлж байгаагаас бусад буюу сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцсон, гэрээний үүргээ биелүүлээгүй зээлдэгчид давтан зээл олгосон асуудал гараагүй байна.

Эргэн төлөгдөх хугацаа дууссан 2,926.5 сая төгрөгийн 734 зээл байгаагаас 4.9 хувь буюу 7 сумын 19.8 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол 5.9 хувь буюу 222.2 сая төгрөгийн 44 зээлийг төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан, 23.3 хувь буюу 957.3 сая төгрөгийн 171 зээлийг төлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн, 65.8 хувь буюу 1,727.2 сая төгрөгийн 483 зээлдэгчид хугацаандаа эргэн төлөлт хийх мэдэгдэл хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 18 / сая төгрөг /

Д/д	Сумд	Нийт зээлдэгчийн		Хугацаа хэтэрсэн зээлийн шийдвэрлэлт							
		Тоо	Мөнгөн дүн	мэдэгдэл өгсөн		шүүхэд шилжүүлсэн		шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлсэн		ямар ч арга хэмжээ аваагүй	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алтанбулаг	28	127.6	6	25.1	17	96.9	5	5.6	0	-
2	Баруунбүрэн	31	80.7	16	30.7	15	50.0	0	-	0	-
3	Баянгол	18	197.0	7	31.0	8	118.9	2	42.3	1	4.8
4	Ерөө	51	138.1	34	127.1	2	7.7	0	-	15	3.3
5	Жавхлант	37	122.8	37	122.8	0	-	0	-	0	-
6	Зүүнбүрэн	69	107.8	59	84.2	1	1.2	9	22.5	0	-
7	Мандал	32	700.9	15	359.7	14	242.2	3	99.0	0	-
8	Орхон	22	36.2	7	28.2	5	7.3	0	-	10	0.7
9	Орхонтуул	33	160.9	6	25.0	25	128.9	1	5.0	1	2.0
10	Сант	27	91.4	8	32.5	14	44.1	5	14.8	0	-
11	Сайхан	78	277.0	68	222.8	10	54.2	0	-	0	-
12	Сүхбаатар	92	275.8	59	127.1	32	148.7	0	-	1	0.0
13	Хушаат	39	135.4	27	104.7	4	13.6	5	13.2	3	3.9
14	Хүдэр	43	87.1	25	63.0	1	4.1	12	14.9	5	5.1
15	Түшиг	54	124.5	32	94.6	22	29.9	0	-	0	-
16	Цагааннуур	28	89.6	28	89.6	0	-	0	-	0	-
17	Шаамар	52	173.7	49	159.1	1	9.6	2	4.9	0	-
Нийт дүн		734	2,926.5	483	1,727.2	171	957.3	44	222.2	36	19.8

Зээлийн эргэн төлөлтийг гэрээний хугацаанд төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн зээлдэгч нарыг хууль хяналтын байгууллагад хандаж, зээлийг барагдуулах арга хэмжээ авч байгаа боловч зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцооогүй байна.

2.4. СХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль журмын хоорондын нийцэл, бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх, сангийн үйл ажиллагаа нь зорилго, зорилтдоо хүрсэн эсэх, цаашид сангийн зорилт, үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн зарим асуудал байгаа эсэх.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

1. Яамдын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 2017 оны 4 дүгээр сараас аймгийн Засаг даргад харьяалагддаг байсан жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн ХХААГ-т шилжин ажиллах болсноор тус журмын 3.2-т заасан аймгийн Засаг даргын эрх, үүргийн заалтууд хэрэгжихгүй болсон байна. Иймд уг заалтуудыг ХХААГ-ын эрх, үүрэг болгон өөрчлөлт оруулж, эрх зүйн орчинг тодорхой болгох, аймгийн хэмжээнд удирдлага арга зүйгээр хангах, хяналт тавих, урамшуулах, зээл олгох зөвшөөрөл олгодог болгох зэрэг эрх, үүргийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
2. СХС-ийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих төрийн захиргааны төв байгууллагыг тодорхой нэр зааж оруулах.
3. СХС хариуцсан мэргэжилтний болон нягтлан бодох бүртгэл хариуцах ажилтны эрх, үүргийг тодорхой тусган оруулж өгөх.
4. СХС хариуцсан ажилтнуудад олгох урамшууллын болон хариуцлагын тогтолцоог тодорхой зааж, оруулж өгөх.
5. Сумын ИТХ-аас томилж байгаа төсөл сонгон шалгаруулах болон хяналтын зөвлөлийн үүрэг, хариуцлага, хоорондын уялдаа, урамшууллын тогтолцоо зэргийг журамд тодорхой тусгах.

Бүлэг 3

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Сангуудын зарцуулалтад өмнөх онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж нь ОНХС- 71.1 хувь, СХС- 81.2 хувийн хэрэгжилттэй байна.

3.1.Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмж дунджаар 71.1 хувийн биелэлттэй байна.

3.1.1.Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 14 зүйлийн зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг 71.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Аймаг, сумдын удирдлагад өгөгдсөн 15 зөвлөмжөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар баталгаажсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх.
2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг Санхүүгийн хяналт, аудитын албаар гүйцэтгүүлж дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлэх.
3. Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй.
4. Багийн ИНХ-аас ирүүлсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх ажлыг журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах.
5. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах.
6. Ерөө, Сайхан, Түшиг сумд 2013 оноос үүссэн 8.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах. /Сант 0.1 сая төгрөгийг авлагыг барагдуулсан/

3.1.2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг биелүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн актыг 100 хувь, албан шаардлагыг 53.3 хувиар хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар, 1,126.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлага, 14.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 1 акт тогтоогдсон байна. Үүнээс төлбөрийн актыг бүрэн барагдуулсан бөгөөд 15 албан шаардлагаас 8-ыг нь хэрэгжүүлж, 53.3 хувийн биелэлттэй дүгнэгдлээ. Ингэснээр акт, албан шаардлагын биелэлт дунджаар 76.6 хувиар биелсэн байна. /Судалгаа №4-т харуулав:/

3.2.Өмнөх СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 85.5 хувь байна.

3.2.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?

Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 56.5 хувьтай байна.

СХС-ийн 2017 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 23 зүйлийн зөвлөмж өгөгдсөнөөс 13 –ийг нь хэрэгжүүлснээр, зөвлөмжийн биелэлт 56.5 хувьтай байна.

Аймаг, сумдын удирдлагад өгөгдсөн зөвлөмжөөс хэрэгжүүлээгүйг нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 19

Д/д	Сумдын ИТХ-ын дарга нарт	Сумдын Засаг дарга нарт:
1	Хяналтын зөвлөл журамд заасан хугацаанд тогтмол шалтгалт явуулж, дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байх.	СХС-гийн эх үүсвэр, эргэлтийг нэмэгдүүлэхийн тулд зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, зээл төлүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авах.
2	Зээл олголт, ашиглалт, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллахын зэрэгцээ хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах тал дээр онцгой анхаарч ажиллах.	Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн менежментийг сайжруулах, үр дүнг нь сум, орон нутгаараа хүртэх томоохон хэмжээний, цөөн тооны төсөл арга хэмжээнд хүрэлцэхүйц хэмжээний зээл олгох бодлого барих.
3	Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Төсөл сонгон шалгаруулах зөвлөлд оролцох иргэний төлөөллийг багийн иргэдийн Нийтийн хурлаар сонгон, иргэдийн оролцоог хангаж ажиллах.
4		Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлгийг тухай бүр авч хэвших.
5		Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлөөс гаргаж буй шийдвэрийг тодорхой болгож, журмын дагуу шалгуур үзүүлэлтээр нь үнэлэх үнэлгээний хуудас баталж, мөрдүүлэх.
6		Иргэдээс ирүүлсэн төслийг хүлээн авч, гарын үсгээр баталгаажуулсан бүртгэл хөтлөх, дэмжигдээгүй төслүүдэд хариуг албан бичгээр өгч байх.
7		Барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст, газар ашиглах, эзэмших гэрээг Газрын албанд бүртгүүлэх, хөдлөх хөрөнгийн эзэмшлийг барьцаалагчид шилжүүлсний үндсэн дээр зээл олгож байх.

3.2.2.Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг биелүүлсэн үү?

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2016 онд СХС-ийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар 3.67 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 7 акт, 1,017.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага тогтоогдсоныг бүрэн барагдуулж акт, албан шаардлагыг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс СХС-ийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил давтагдан гарсаар байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

СХС-ийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар нийт **4,153.2 сая төгрөгийн** зөрчил илэрснээс **191.0 сая төгрөгийн** зөрчлийг арилгуулах албан шаардлага, **3,962.2 сая төгрөгийн** зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлж байна.

Нэг. Албан шаардлага:

1. Гэрээний хугацаа хэтрүүлсэн зээлд алданги тооцоогүйгээс **123.9 сая төгрөгийн** орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 11-д харуулав/
2. СХС хариуцсан ХАА-н тасгийн мэргэжилтний зээл, зээлийн хүүгийн авлагын тооцоолол зөрүүтэйгээс санхүүгийн тайланд Алтанбулаг, Жавхлант сумд **34.9 сая төгрөгөөр** илүү, Түшиг, Хушаат сумд **32.2 сая төгрөгөөр** дутуу тусгасан байна. /Дэлгэрэнгүйг Хүснэгт 18-д харуулав/

Хоёр. Зөвлөмж:

1. СХС-аас олгосон нийт **3,427.2 сая** төгрөгийн зээл эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.
2. Зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс хүүгийн орлогыг 90.7 хувь буюу **423.5 сая төгрөгийг** дутуу төвлөрүүлсэн байна.
3. Нийт олгосон зээлийн 22.7 хувь **111.5 сая төгрөгийг** зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цулуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сумдууд хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги тооцож, төлөвлөөгүй бөгөөд зээлийн эргэн төлөлт, хүүгийн төлөвлөсөн орлогын 60.7 хувийг дутуу төвлөрүүлсэн байна.
- СХС-аас олгосон нийт 3,427.5 сая төгрөгийн зээл чанаргүй болон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд хамрагдаж байна.
- Зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс хүүгийн орлогын 90.7 хувийг дутуу төвлөрүүлсэн байна.
- Гэрээний хугацаа хэтрүүлсэн зээлд алданги тооцоогүйгээс 123.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.
- Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаагүй, иргэдээс төсөл хүлээн авч, хариу өгсөн тухай бүртгэл

- хөтлөөгүй байгаа зэрэг нь сонгон шалгаруулалт шударга явагдахгүй байх, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.
- Сумдын сонгон шалгаруулах зөвлөл нь зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай эсэхийг бодитоор үнэлээгүй байна.
 - Зээлийн гэрээний эрх, үүргийн биелэлт хангалтгүй байгаагаас зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, хугацаандаа төлөгдөхгүй байх зэргээр гэрээний зарим зүйл, заалт хэрэгжээгүй байна.
 - СХС-аас олгосон зээлийн 22.7 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
 - Зээлийн барьцаанд барьцаа болох эрх зүйн чадамжгүй хөрөнгүүдийг авч байгаа нь олгосон зээл хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх үндсэн нөхцөл болж байна.
 - СХС-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.
 - 4 сумын СХС хариуцсан мэргэжилтний зээл, зээлийн хүүгийн авлагын тооцоолол нь санхүүгийн тайланд тусгагдсан авлагаас 67.1 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. / Алтанбулаг, Жавхлант сумд 34.9 сая төгрөгийг дутуу, Түшиг, Хушаат сумд 32.2 сая төгрөгийг илүү тусгасан. /
 - Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй зээлдэгчдэд хариуцлага тооцох ажил хангалтгүй байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл буурахгүй байна.
 - СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдалд хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийг сумдууд бүрэн хэрэгжүүлэхгүй байх, холбогдох байгууллагуудын зүгээс нэгдсэн бодлого, арга зүйгээр хангахгүй байх зэргээр байгууллагууд өөр хоорондоо уялдаа холбоо муутай ажиллаж байна.
 - Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 56.5 хувьтай байна.
 - Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр-д:

1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн хүү, алданги тооцох арга зүй, барьцаа хөрөнгийн төрөл, түүний эрх зүйн чадамжийг хангах нэгдсэн бодлого, аргачлалаар сумдыг хангах.
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, бүртгэл тооцоолол, хяналт шалгалт хариуцсан байгууллагуудын өөр хоорондын уялдаа, холбоог хангах.
3. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах, зээл төлүүлэх хөшүүрэг болж чадах эрх зүйн чадамж бүхий хөрөнгүүдийг барьцаа хөрөнгөөр авч үлдэх замаар эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. СХС-ийн орлого, зарлагыг сумын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталж, хэрэгжүүлэх.

ОНХС, СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

2. Хяналтын зөвлөлийн шалгалтыг тогтмол явуулж, дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын иргэдэд мэдээлж байх.
3. Зээл олголт, ашиглалт, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах.
4. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Сумдын Засаг дарга нарт:

1. СХС-ийн эх үүсвэр, эргэлтийг нэмэгдүүлэхийн тулд зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, зээл төлүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2. СХС-аас олгох зээлийн үр дүнг нь сум, орон нутгаараа хүртэх томоохон хэмжээний, төсөл арга хэмжээнд зээл олгох бодлого барих.
3. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлд оролцох иргэний төлөөллийг багийн иргэдийн Нийтийн хурлаар сонгон, иргэдийн оролцоог хангаж ажиллах.
4. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлгийг тухай бүр авч хэвших.
5. Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлөөс гаргаж буй шийдвэрийг тодорхой болгож, журмын дагуу шалгуур үзүүлэлтээр нь үнэлэх үнэлгээний хуудас баталж, мөрдүүлэх.
6. Иргэдээс ирүүлсэн төслийг хүлээн авч, гарын үсгээр баталгаажуулсан бүртгэл хөтлөх, дэмжигдээгүй төслүүдэд хариуг албан бичгээр өгч байх.
7. Барьцаа хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст, газар ашиглах, эзэмших гэрээг ГХБХБГ-т бүртгүүлэх, хөдлөх хөрөнгийн эзэмшлийг барьцаалагчид шилжүүлсний үндсэн дээр зээл олгож байх.

СХС хариуцсан мэргэжилтэн болон нягтлан бодогч нарт:

1. Хугацаандаа төлөгдөөгүй зээлийн дүнд гэрээний дагуу алданги ногдуулж, орлогыг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, тайлагнах.
2. Алтанбулаг, Жавхлант, Түшиг, Хушаат сумд зээл, зээлийн хүүгийн төлөлт, үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, тайлагнах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БААСАНСҮРЭН
Б.ЭРДЭНЭЗУЛ
Ж.ЦОГТ

**АЙМАГ, СУМДЫН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР
ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

/ сая төгрөг/

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих дүн
Хөрөнгө оруулалт		1		1,395.6	754.3
1	ЗАСАГ ДАРГА	2		1,345.6	704.3
1.1	Хөрөнгө оруулалт	3		1,140.0	498.6
Шилжих хөрөнгө оруулалт		4		760.0	118.6
1.1.1	Усан бассейны дулааны шугамын ажил / шинээр баригдсан сургууль хүртэл дулааны шугам/	5	2013-2017	700.0	59.0
1.1.2	Сайхан сумын олимптаеквондогийн Мараната клубын барилгын гадна, дотно сантехникийн ажил	6	2016-2017	60.0	59.6
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		7		380.0	380.0
1.1.3	Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн саравчийг гүйцээж стандарт таримал зүлэгтэй хөл бөмбөгийн талбай байгуулах	8	2017-2017	327.0	327.0
1.1.4	Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт томограф аппарат суурьлуулах, тээвэрлэх	9	2017-2017	53.0	53.0
1.2	Тоног төхөөрөмж	10		94.1	94.1
1.2.1	Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эрчимт эмчилгээний тасагт тоног төхөөрөмж авах	11	2017-2017	48.5	48.5
1.2.2	Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах	12	2017-2017	45.6	45.6
1.3	Их засвар	13		111.5	111.5
1.3.1	Орхон сумын сургуулийн дээвэр засвар	14	2017-2017	80.0	80.0
1.3.2	Аймгийн нэгдсэн эмнэлэгийн эрчимт эмчилгээний тасгийн их засвар	15	2017-2017	31.5	31.5
Хөтөлбөр, төсөл арга хэмжээ		16		50.0	50.0
2.1.1	Баяр, наадам зохион байгуулах зардал	17	2017-2017	50.0	50.0
Сумдад хуваарьлагдах дүн		18		1,144.7	794.6
Суурь зарлага санхүүжих дүн		19		725.2	725.2
НИЙТ ДҮН		20		3,265.6	2,274.1



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

2018.11.28 № 2/618
талай _____ ны № _____ т

Тайлбар хүргүүлэх тухай

"Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд дараах тайлбаруудыг хүргүүлж байна. Үүнд:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэлд тавигдах захиалагчийн хяналтыг сайжруулж, зураг, төсөв зохиогчийн хяналтын тайлан, дүгнэлт зэрэг холбогдох баримт материалыг үндэслэн санхүүжилтийг олгож байх гэсэн зөвлөмжийн хүрээнд

-Хөрөнгө оруулалтаар хэргэжиж буй барилга байгууламж, их засвар, инженерийн шугам сүлжээ, зам, гүүрийн ажилд "Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ захиалагчийн хяналт, зураг төсөв зохиосон байгууллага зохиогчийн хяналтын тайлан, дүгнэлтийг үндэслэн хяналтын зардлыг олгож байна.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тухай бүр тогтоож, аймгийн ОНӨГ-тай хамтран бүртгэлд тусгаж байх гэсэн зөвлөмжийн хүрээнд

-Хөрөнгө оруулалтын гэрээт ажлыг байнгын ашиглалтад хүлээлцэх комисст ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулдаг бөгөөд гүйцэтгэлийн бичиг баримтын бүрдэлд өмч хөрөнгийг бүртгэн авсан тухай ашиглагчийн тодорхойлолтыг хавсарган архивлаж байна.

ДАРГА



Ө.СУВДАА

Alban bichig My Doc A4

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР

Тайлбар 1:

Тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2.2-т “Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг НТШ-аар зохион байгуулсан 1, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 зэрэг нийт 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгэхээс 4 төсөл, арга хэмжээний / 1 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй, зөвхөн худалдан авах ажиллагаа нь хийгдсэн / явцын болон техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн бол 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан бассейны дулааны шугамын ажил”, 45.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан суманд нийтийн тээврийн үйлчилгээний автобус авах” 2 төсөл, арга хэмжээнд хяналт хийлгээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 37.2⁵², Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2⁵³ дахь заалтыг зөрчсөн байна.” гэж дурдагдсан.

Тайлант онд дээрх 2 төсөл, арга хэмжээний явц болон гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байсан тул зөвлөмж өгөгдсөн бөгөөд тайлбарыг хүлээн авах боломжгүй юм.

Мөн 1.2.2-т “Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх барилга угсралт, их засварын 496.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний зураг төсөв болон зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэхээр Талхун Арал ХХК-тай гэрээ байгуулснаас 59.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний явц болон гүйцэтгэлд хяналт хийсэн бол 437.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээнд хяналт хийгдэлгүйгээр зөвхөн ажил хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ажилласан байна. Зураг, төсөв зохиогчийн хяналтын зардалд аймгийн ОНХС-аас 3.5 сая төгрөгийг олгосон боловч зохиогчийн хяналт хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээг дүгнээгүй, хяналтын тэмдэглэл, дүгнэлт зэргийг бүрдүүлээгүй, өөрөөр хэлбэл анхан шатны баримтаар баталгаажаагүй буюу хяналт хийгдээгүй байхад санхүүжилтийн гүйлгээ хийсэн нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавигдах хяналт хангалтгүй байх эрсдэлийг үүсгэж байна.” гэж дурдагдсан.

Талхун Арал ХХК нь 2017 онд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн эсэхийг нотлох зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлт, тайлан зэрэг анхан шатны баримт материал байхгүй, захиалагч аймгийн ЗДТГ нь зохиогчийн хяналтын гэрээг дүгнэж, үнэлээгүй байсан тул зөвлөмж өгөгдсөн бөгөөд тайлбарыг хүлээн авах боломжгүй юм.

Тайлбар 2:


Тайлангийн 1 дүгээр бүлгийн 1.2.2-т “Харин аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 118,5 сая төгрөгийн өртөг бүхий дараах хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

⁵² Захиалагч барилгын ажлын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

⁵³ Энэ дүрмийн 2.1-д заасан барилга захиалагч нь мөн дүрмийн 3.1-д зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 3.2.5. орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга захиалагчийн албаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх

- Захиалагч аймгийн ЗДТГ болон Орон нутгийн өмчийн газрын харилцан уялдаагүй ажиллагааны улмаас 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Усан бассейны дулааны шугам”,
- Хувийн эзэмшлийн барилгад зориулалтын бусаар зарцуулсан 59.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан сумын олимп таеквондогийн Мараната клубын барилгын гадна, дотор сантехникийн засвар” зэрэг болно “ гэж дурдагдсан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон дээрх хөрөнгийг 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй бөгөөд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын “Удирлагын зөвлөл”-ийн хурлаар уг алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.



АЙМГИЙН ХХААГ-ЫН ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР

Тайлбар 1:

Нийцлийн аудитын дүнд үндэслэн аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр-д “1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн хүү, алданги тооцох арга зүй, барьцаа хөрөнгийн төрөл, түүний эрх зүйн чадамжийг хангах нэгдсэн бодлого, аргачлалаар сумдыг хангах.

2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, бүртгэл тооцоолол, хяналт шалгалт хариуцсан байгууллагуудын өөр хоорондын уялдаа, холбоог хангах.

3. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулах, зээл төлүүлэх хөшүүрэг болж чадах эрх зүйн чадамж бүхий хөрөнгүүдийг барьцаа хөрөнгөөр авч үлдэх замаар эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авах.” гэсэн зөвлөмжийг хүргүүлэхээр тайлангийн төсөлд дурдсан юм.

Аймгийн ХХААГ-аас 2018 онд дээрх зөвлөмжтэй холбоотой ажлуудыг хийсэн талаар холбогдох баримт материалыг хавсаргасан байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас “СХС-ийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д нийцлийн аудитыг хийсэн тул тайлбарыг хүлээн авах боломжгүй бөгөөд СХС-ийн 2018 оны үйл ажиллагаанд хийх аудитаар хэрэгжилтийг тооцох боломжтой юм.